




НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

## Жилийн тайлан

# 2011



## ЖИЛИЙН ТАЙЛАН 2011

---

Жамьян гүний гудамж - 5/1, Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар - 210648, Монгол Улс

Утас: (976-11) 313207,

Факс: (976-11) 324857

Вэб сайт: <http://www.forum.mn>

Жич: Энэ тайланд гэрэл зурагчин Г.Ган-Өлзийгийн Монголын байгаль орчны  
сэдэвт зургуудыг толилууллаа

# ГАРЧИГ

|   |    |
|---|----|
| ӨМНӨТГӨЛ .....  | 4  |
| ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР .....   | 7  |
| Хүний эрх .....   | 8  |
| Шүүхийн хараат бус байдал .....                                   | 11 |
| Төрийн ил тод, хариуцлагатай байдал, иргэний нийгмийн оролцоо ... | 13 |
| Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө .....                                | 22 |
| Чөлөөт, шударга сонгууль .....                                    | 23 |
| ЭДИЙН ЗАСГИЙН ХӨТӨЛБӨР .....                                      | 25 |
| Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга .....            | 26 |
| Олборлох салбарын бодлогын асуудлууд .....                        | 28 |
| Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо .....                   | 29 |
| Эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ .....                        | 31 |
| Бизнесийн орчин .....   | 34 |
| Орон нутгийн эдийн засгийн хөгжил .....                           | 35 |
| НИЙГЭМ, БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР .....                                | 37 |
| Нийгмийн үйлчилгээний хүртээмж .....                              | 38 |
| Боловсролын үйлчилгээний хүртээмж .....                           | 40 |
| Залуучуудын оролцоог дэмжих хөтөлбөр .....                        | 42 |
| ХӨГЖЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ .....                                     | 43 |
| ПОРТАЛ САЙТ .....   | 44 |
| БОДЛОГЫН АСУУДАЛ /Цуврал/ .....                                   | 45 |
| БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР .....                      | 46 |
| ЭРДМИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР .....                                  | 47 |
| ХЭВЛЭН НИЙТЛЭЛ .....  | 49 |
| ОРЧУУЛГЫН ТӨСӨЛ .....   | 50 |
| БУСАД ХАВСРАЛТ .....  | 51 |
| ДОРНО ДОРНО ХӨТӨЛБӨР .....  | 52 |
| САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....   | 53 |
| АЖИЛТНУУД .....   | 59 |

# ТОВЧИЛСОН ҮГ

|           |   |
|-----------|---|
| АНУ       | Америкийн Нэгдсэн Улс                                   |
| БНСУ      | Бүгд Найрамдах Солонгос Улс                             |
| БНХАУ     | Бүгд Найрамдах Хятад Ард Улс                            |
| БСШУЯ     | Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам                       |
| ДНБ       | Дотоодын Нийт Бүтээгдэхүүн                              |
| ЗДТГ      | Засаг Даргын Тамгын Газар                               |
| ЗХУ       | Зөвлөлт Холбоот Улс                                     |
| ЛЭОС      | Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны Сан                        |
| МУИС      | Монгол Улсын Их Сургууль                                |
| НДЭХ      | Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн                   |
| ННФ       | Нээлттэй Нийгэм Форум                                   |
| НҮБ       | Нэгдсэн Үндэстний Байгууллага                           |
| ОУИТБС    | Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын<br>Санаачилга     |
| ТАН эвсэл | Төлсөн Авснаа Нийтэл эвсэл                              |
| ТББ       | Төрийн бус байгууллага                                  |
| УИХ       | Улсын Их Хурал  |
| ХЗДХЯ     | Хууль Зүй Дотоод Хэргийн Яам                            |
| ХХААХҮЯ   | Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам              |
| ХХИ       | Хэрэглэгчийн Хүлээлтийн индекс                          |
| ХЭЗ       | Хүний Эрхийн Зөвлөл                                     |
| ХЭҮК      | Хүний Эрхийн Үндэсний Комисс                            |
| ЦЭХЗС     | Цахилгаан, Эрчим Хүчний Засаглалын<br>Санаачилга        |
| ЭМШУИС    | Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль                |
| IRIM      | Хараат Бус Судалгааны Хүрээлэн                          |
| JSTOR     | Жэй-Стор онлайн сан                                     |
| OECD      | Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн<br>Байгууллага |

Нээлттэй Нийгэм Форум (ННФ)-ын 2011 оны тайланг Та бүхэнд толилуулж буйдаа таатай байна. Энэ он бидний хувьд өмнө эхлүүлсэн олон чухал санаачилгаа бататган хэрэгжүүлэхийн зэрэгцээ бас ч гэж нэлээдгүй олон ажлыг шинээр эхлүүлсэн жил байлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан шүүхийн тухай багц хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагааг дэмжиж олон талын оролцоотой хэлэлцүүлэг өрнүүлэх, олон улсын туршлага судлах, зарим хуулийн төсөл боловсруулахад оролцох зэргээр манай оронд өрнөж буй шүүхийн шинэтгэлд хувь нэмрээ орууллаа. Түүнчлэн ННФ Хүний эрхийн ТББ-уудтай хамтран Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын хэрэгжилтийн талаар сүүдрийн илтгэл бэлтгэж хүний амьд явах, эрүүдэн шүүхээс ангид байх, шударга шүүхээр шүүлгэх эрхийн нөхцөл байдлыг НҮБ-ын Хүний Эрхийн Хороонд танилцуулсан нь Монголын иргэний нийгмийн хувьд шинэ туршлага хуримтлуулсан чухал арга хэмжээ боллоо.

Эдүгээ долоо дахь жилдээ хэрэгжиж буй төрийн бус байгууллагуудад зориулсан “Мониторингийн тэтгэлэгт хөтөлбөр” маань 2011 онд орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудыг дэмжихэд илүүтэй анхаарлаа. Архангай, Баян-Өлгий, Говьсүмбэр, Увс, Баянхонгор зэрэг аймагт 6 төрийн бус байгууллага анх удаа иргэдийн сурч боловсрох, хөдөлмөрлөх эрх, нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмж, төсвийн зарцуулалт гэх мэт чиглэлээр мониторинг хийж, цаашид орон нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалж ажиллах зохих туршлага хуримтлуулсан байна.

Тэрчлэн орон нутгийн түвшинд шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж нэг талаас иргэдийн оролцох идэвхи сонирхлыг дээшлүүлэх, нөгөөтэйгүүр иргэдийн төлөөлөгчдийн хурлыг илүү нээлттэй болгох, иргэний танхимын үйл ажиллагааг хэвшүүлэх, иргэдийн нийтийн хурлыг зохион байгуулж явуулах журмыг шинэчлэх зэрэг иргэдийн оролцооны арга хэлбэрүүдийг төлөвшүүлж байна.

Энэ онд ННФ олон жил идэвх зүтгэл гарган байнга анхаарч ажилласан бас нэгэн чухал ажлынхаа үр дүнг үзсэн жил болсныг дурдахад баяртай байна. Энэ бол УИХ-ын сонгуулийн шинэ хуульд сонгуулийн үйл явцыг илүү боловсронгуй, ил тод, хяналттай болгоход чиглэсэн олон өөрчлөлт орсон явдал юм. Энэ хуулиар сонгогчдын нэрийн жагсаалт гаргах үйл явцыг өмнөхөөс цэгцтэй, тодорхой болгосноос гадна дотоодын иргэний нийгмийн байгууллагууд сонгуульд хөндлөнгийн ажиглалт хийх цоо шинэ боломж нээгдлээ.

2011 онд Монгол Улс ээлжит тайлангаа гаргаснаас гадна олон улсын нэр хүндтэй шагнал болох ОУИТБС-ын даргын нэрэмжит шагналыг хүлээн авсан бөгөөд үүнд иргэний нийгмийн оролцогчид, түүний дотор ННФ-ын хувь нэмэр их байсныг тэмдэглэн хэлэхийг мөн хүсч байна. Олон улсын түвшинд нийт 35 улс орон ОУИТБС-ыг хэрэгжүүлж байгаа ба тус байгууллагын олон улсын удирдах хороонд иргэний нийгмийг төлөөлж ННФ-ын менежер хоёр жилийн хугацаатай ажиллаж эхэллээ.

ННФ олон улсын хэмжээний хоёр ч санаачилгад нэгдлээ. Юуны өмнө 2011 онд шинээр зарлагдсан Төсвийн Ил Тод Байдлын Даян Дэлхийн Санаачилгад ННФ нэгдэж, олон улсын төсвийн ил тод, нээлттэй байдлын стандарт, шилдэг туршлагыг Монголд хэрэгжүүлж ажиллах бололцоотой боллоо. Нөгөө нь “Эрчим Хүчний Засаглалын Санаачилга” бөгөөд энэ санаачилгыг Монголд хэрэгжүүлж эхэлсэн нь бас нэг шинэ ажил байлаа.

Уул уурхайн салбарын орлогын менежментийн талаар хэрэгжүүлж буй болон цаашид хэрэгжүүлэх бодлого ямар байхаас шалтгаалах Монголын ирээдүйн дүр зургийг боловсруулж олон нийтэд танилцуулахаар бэлтгэж байна.

Энэ мэтчилэн бидний хийж бүтээсэн, бүтээхийг оролдон зорьж яваа үйл хэргийн тухай ээлжит тайлан мэдээлэлтэй Та бүхэн уншиж танилцаад санал сэтгэгдлээ хуваалцах аваас бид талархан хүлээн авах болно.

*Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал  
П.Эрдэнэжаргал*

# ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР

# ХҮНИЙ ЭРХ

## ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ МЕХАНИЗМЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Нээлттэй Нийгэм Форумын 2010 онд эхлүүлсэн хүний эрхийн чиглэлээр ажилладаг ТББ-уудад дэмжлэг үзүүлэх төслийн хүрээнд 2011 онд Швейцарийн Женев хотноо болсон НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн хуралдаанд Монголын иргэний нийгмийн төлөөлөл анх удаа оролцлоо. Энэхүү хурлаар НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн 129 зөвлөмжөөс 125-ыг нь Монгол Улс хүлээн зөвшөөрсөн тухай тогтоолыг баталсан нь Монголын Засгийн газраас хүний эрхийн чиглэлээр олон улсын түвшинд авч буй маш том амлалт юм. Эдгээрт Монгол Улсын Ерөнхийлөгчийн цаазаар авах ялаас түдгэлзэх шийдвэрийг талархан хүлээн авч улмаар хууль тогтоомжоос халах, эрүүдэн шүүхийн эсрэг үндэсний механизмтай болох, бэлгийн цөөнхийн эрхийг хүлээн зөвшөөрч хамгаалах, үзэн ядалтын гэмт хэргийн эсрэг тэмцэх, гэр бүлийн хүчирхийлэлийн эсрэг дорвитой арга хэмжээ авах, хүн худалдаалах гэмт хэрэгтэй бүх талаар тэмцэх зэрэг зөвлөмжийг

өгсөн юм. Зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж буйг 2015 онд тайлагнахаар боллоо. Түүнчлэн НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн зөвлөмжийг хэрэгжүүлэхийг хүний эрхийн ТББ-уудын форумын зүгээс уриалан хэрэгжилтэд нь мониторинг хийхээр боллоо. Түүнчлэн 2011 оны зургадугаар сард НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын газар Монгол Улсын Гадаад Хэргийн Яамтай хамтран НҮБ-ын ХЭЗ-ийн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэх уулзалт зохион байгуулахад хүний эрхийн ТББ-уудын форум бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож байр сууриа илэрхийллээ.

Хүний эрхийн ТББ-уудын хувьд 2011 онд олж авсан бас нэг чухал туршлага нь Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын хэрэгжилтийн талаар сүүдрийн илтгэл бэлтгэж НҮБ-ын Хүний Эрхийн Хороонд илгээсэн явдал юм. ННФ тус пактын 4, 6, 10, 14-р зүйлд заасан шударга шүүхээр шүүлгэх эрх, иргэний халдашгүй дархан байх эрх чөлөө болон 2008



оны Долдугаар сарын 1-тэй холбоотой хүний эрхийн зөрчлийн тухай тайланг бэлтгэн уг илтгэлд тусгууллаа. Түүнчлэн Швейцарийн Женев хотноо байрладаг Иргэний болон Улс Төрийн Эрхийн Төвийн дэмжлэгтэйгээр Хүний Эрх Хөгжил төв, Глоб Интернэшнл ТББ-уудын хамт 2011 оны гуравдугаар сарын 21-22-нд АНУ-ын Нью Йорк хотноо хуралдсан НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны хуралд оролцон тодруулга мэдээлэл хийсэн нь Монголын иргэний нийгмийн байгууллагууд НҮБ-ын гэрээний байгууллагуудтай харилцах онцгой туршлага болсон юм.

Ийнхүү НҮБ-ын механизмуудаар дамжуулан Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлыг дэлхий нийтэд таниулсан нь иргэний нийгмийн байгууллагуудын олон улсын хамтын ажиллагаанд чухал хувь нэмэр боллоо. Тухайлбал, ННФ Ази-Европын сангаас зохион байгуулсан Зүүн хойд Азийн бүс нутгийн иргэний нийгмийн ээлжит чуулга уулзалтад оролцож, бүс

нутгийн иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа бэхжүүлэв. Монгол Улс Зүүн хойд Азийн бүс нутагт цаазаар авах ялыг халах, эрүүдэн шүүхтэй тэмцэх, шүүхийн шударга, хараат бус байдлыг хангах талаар дэвшилттэй байр суурьтай байгаа нь туршлага солилцох явцад ажиглагдлаа.

2011 онд ННФ Хүний Эрхийн Үндэсний Комиссын орон тооны бус зөвлөлийн гишүүн болсон бөгөөд 2011 оны 12 дугаар сарын 6-нд Хүний эрхийн өдрийг тохиолдуулан ХЭҮК-той хамтран их дээд сургуулийн оюутнуудын дунд хүний эрхийн сэдвээр мэтгэлцээн зохион байгууллаа.

Мөн Эмнести Интернэшнл Монгол ТББ нь Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн тэтгэлгээр цаазаар авах ялыг халах төслийг амжилттай хэрэгжүүлж Зүүн хойд Азийн бүсдээ цаазаар авах ялыг халсан анхны улс болсон нь иргэний нийгмийн хувьд хуваалцах ёстой нэг том үйл явдал боллоо.

## ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭДЭД ҮЗҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА

ННФ-ын 2003 оноос хэрэгжүүлсэн “Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх эрх зүйн туслалцаа” төсөл төгсгөлийн шатандаа орлоо. Төслийн хүрээнд 2011 онд ННФ Өмнөд Африкийн мэргэжилтэн Давид Маккуайд Мэсоны тусламжтайгаар Эрх зүйн туслалцааны тухай хуулийн үзэл баримтлалыг боловсруулахад агуулга болоод арга зүйн дэмжлэг үзүүллээ. Энэхүү хуулийн төслийг боловсруулахад олон улсын төстэй хууль тогтоомжийг судлах ажилд дэмжлэг үзүүлсэн бөгөөд 2011 онд хуулийн төслийг боловсруулж дуусан холбогдох байгууллагуудаас санал авч эхлэв. Хуулийн зорилго нь иргэд эрх зүйн үйлчилгээг цаг алдалгүй чанартай авахад дэмжлэг үзүүлэх, үнэ төлбөргүй туслалцаа авах эрхийг баталгаажуулахад оршино.

Эрх зүйн туслалцааны үндэсний тогтолцооны удирдлага, бүтэц, зохион байгуулалт, санхүүжилтийн асуудлыг хуулийн хүрээнд зохицуулах оролдлого хийгдэж эхэллээ. Ялангуяа үнэ төлбөргүй туслалцаа авах эрх бүхий иргэдийг хуулиар тодорхойлон өгч байгаа нь тэдний эрхийг баталгаажуулах чухал зохицуулалт юм. Энэхүү хуулийн төслийг Шүүгчийн тухай багц хууль, тэр дундаа Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Өмгөөллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл зэрэг хуулийн төслүүдтэй нарийн нягт уялдуулах нь чухал байгаа юм.

Эдүгээ Монгол улсын хэмжээнд нийт 35 эрх зүйн туслалцааны төв үйл ажиллагаагаа явуулж байна.

# ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ

ННФ 2008 оноос эхлэн шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх чиглэлээр судалгаа, дүн шинжилгээ хийх, олон нийтийн санаа бодлыг бодлого боловсруулагчдад хүргэх, бүх талын оролцоотой бодлогын шинэтгэл хийх үйл явцыг дэмжин ажиллаж байна.

2011 он шүүхийн шинэтгэлийн үйл явцад ихээхэн дэвшил гарсан жил боллоо. Энэ онд ННФ-аас шүүхийн шинэтгэлийг дэмжих чиглэлд дараах үйл ажиллагааг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Шүүхийн Ерөнхий Зөвлөл зэрэг байгууллагатай хамтран хэрэгжүүлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар 2011 оны дөрөвдүгээр сард шүүхийн шинэтгэлийн талаар олон талын оролцоотой үндэсний хэлэлцүүлэг зохион байгуулахад дэмжиж хамтран ажиллав. Энэхүү үндэсний хэлэлцүүлгийн гол үр нөлөө нь шүүхийн болон хуулийн байгууллагуудын шинэтгэлийн талаар эрдэмтэн судлаач, бодлого боловсруулагчид, мэргэжлийн хуульчдын өргөн хүрээний оролцоотой шүүмж хэлэлцүүлэг өрнүүлж практик ач холбогдол бүхий тодорхой санал зөвлөмж гаргасанд оршино.

ННФ үндэсний хэлэлцүүлгийн дараа байгуулагдсан шүүхийн тухай багц хуулийг боловсруулах ажлын хэсэгт орж Шүүгчийн эрх зүйн байдлын тухай болон Шүүхийн иргэний төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд өмнө хэрэгжүүлсэн судалгаа шинжилгээний дүн болон олон улсын туршлагад тулгуурласан тодорхой зөвлөмж санал болгосон юм. Тэрчлэн шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүд, шүүхийн захиргааны ажилтнуудын төлөөллийг БНСУ-ын Сөүл хотноо иргэдийн оролцоотой шүүх ажиллагааны практиктай танилцуулах аяллыг зохион байгууллаа. БНСУ нь дөрвөн жилийн өмнөөс энэ чиглэлд шинэтгэл явуулж эхэлсэн бөгөөд сүүлийн хоёр жилийн хугацаанд шүүх хуралдаанд иргэдийг төлөөлөгчөөр суулган шүүхийн альтернатив шийдвэр гаргах тангарагтны шүүхийн тогтолцоог хуулийн хүрээнд туршиж байгаа юм.

ННФ-аас Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг, түүгээр санал болгож буй шинэ механизмуудыг олон нийт болон бодлого

боловсруулагчид, хэрэгжүүлэгчдэд таниулах зорилгоор “Шүүхэд хэрэг маргаан шийдвэрлэх ажиллагаан дахь иргэдийн оролцоо” сэдэвт бодлогын тойм бэлтгэн нийтийн хүртээл болголоо. Иргэдийн бодит оролцоог хангах нь шүүхийг ил тод болгохын зэрэгцээ хараат бус байдлыг хангах нэн чухал баталгаа болох юм. Иргэд шүүхийн үйл ажиллагаанд оролцсноор тэдний эрх зүйн боловсролд ч хувь нэмэртэй.

Шүүхийн шинэтгэлийн талаар болон шүүхийн үйл ажиллагааг сурвалжлах сэтгүүл зүйн стандартыг бий болгох үүднээс “Шүүх эрх мэдэл ба сэтгүүлчид” төслийг 2011 онд эхлүүллээ. Төслийн хүрээнд шүүх, хэвлэл мэдээллийнхний харилцан ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэх бөгөөд нийт 20 гаруй сэтгүүлчийг орон нутгийн шүүхийн өдөр тутмын үйл ажиллагаатай танилцуулан шүүх хуралдааныг сурвалжлахад баримтлах зарчим, дүрмийг боловсруулж сэтгүүлчдэд зориулсан гарын авлага бэлтгэх юм.

УИХ-д өргөн баригдаж зарим нь батлагдаад буй шүүхийн тухай багц зургаан хууль нь шүүх эрх мэдлийн хүрээнд хараат

бус байдлыг бэхжүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн асар өргөн хүрээний шинэтгэл болох юм. Үүнээс заримыг нь онцлон дурдвал:

- Шүүхийн захиргааны асуудал, шүүгчийн эрх зүйн байдал, шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдал, эвлэрүүлэн зуучлал зэрэг асуудлыг тусгайлсан хуулиар зохицуулахаар болсон нь эрх зүйн орчныг улам нарийн болгож байгаа юм.
- Хуульчийн эрх зүйн байдлын тухай бие даасан хуулийн төсөл нь шүүх, хуулийн байгууллагын хүний нөөцийн бодлогыг бүхэлд нь шинэчилсэн хууль эрх зүйн акт болох юм. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд шүүгчид тавигдах шалгуур, сонгон шалгаруулах үйл явцыг нээлттэй, шударга болгох механизмуудыг тодорхой оруулсан бөгөөд шүүгчдийн мэргэжлийн ёс зүй, сахилга хариуцлагын асуудлыг ч орхигдуулаагүй байна.

- Шүүхийн Ерөнхий Зөвлөл шүүхийн үйл ажиллагааг ил тод болгох нь хараат бус байдлыг хангах урьдчилсан нөхцөл гэдгийг хүлээн зөвшөөрч шүүхийн шийдвэрийг олон нийтэд

ил тод болгох ажлыг хуулийг батлагдахаас өмнө практикт нэвтрүүлж эхэлсэн нь шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг дэмжсэн чухал алхам болж байна.



Улаанбаатар хот

# ТӨРИЙН ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦОО

## ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ХЯНАЛТ, МОНИТОРИНГ



Нээлттэй Нийгэм Форум 2005 оноос эхлэн төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад төрийн бус байгууллагуудын хөндлөнгийн хяналт тавих оролцоог нэмэгдүүлэх, чадавхийг бэхжүүлэх зорилгоор мониторингийн тэтгэлэгт хөтөлбөрийг жил бүр нээлттэй зарлан хэрэгжүүлж байна. Энэ хугацаанд хөтөлбөрт оролцсон ТББ-уудын ихэнх нь Улаанбаатарт үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд байсан юм. Иймд 2011 онд харьцангуй туршлага багатай орон нутгийн ТББ-уудыг татан оролцуулж чадавхижуулах зорилт тавьж, мониторинг, нөлөөллийн чиглэлээр туршлага хуримтлуулсан зөвлөх байгууллагуудыг сонгон хөдөөд ажиллуулж орон нутгийн ТББ-уудтай мэдээлэл солилцох боломжоор хангалаа. Энэ ажлын хүрээнд Өвөрхангай аймгийн Орон Нутгийн Санаачилга, Улаанбаатар хотын IRIM судалгааны төв, Хөгжлийн Цонх болон Хил Хязгааргүй Алхам зэрэг туршлагатай ТББ-ууд Баянхонгор, Архангай, Дундговь, Увс, Баян-Өлгий, Дорноговь аймагт ажиллан иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл,

чадавхид үнэлгээ өгч сургалт зохион байгууллаа.

Зөвлөх байгууллагуудын ажилласан аймгуудад иргэний нийгмийн чадавх, нөхцөл байдал ямар байгааг тоймлон авч үзвэл дараахь дүр зураг харагдаж байна. Үүнд:

Дорноговь аймагт хорь орчим ТББ байдгаас тал хүрэхгүй нь тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа ч тодорхой тогтсон чиглэлгүй, ихэнхдээ иргэдэд янз бүрийн асуудлаар зөвлөгөө өгөх, сургалт явуулах төдийгөөр хязгаарлагддаг ажээ. Энэ аймагт зөвхөн хоёр ТББ л мониторинг хийж байсан туршлагатай аж. Баян-Өлгий аймагт 30 ТББ байгаагаас дөрвөн нь л тогтвортой үйл ажиллагаа явуулж байсан бол Увс аймгийн хувьд энэ тоо бүүр цөөн байна. Бусад аймагт ч иргэний нийгмийн чадавхи, нөхцөл байдал төстэй харагдаж байна. Жишээ нь, Орон Нутгийн Санаачилга ТББ-ын ажилласан Баянхонгор аймагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг цөөн ТББ-ын үйл ажиллагаа харьцангуй тогтмол бол бусад байгууллагын хувьд төрийн байгууллагад

ажилладаг хүмүүс удирддаг эсвэл ахмадын холбоо гэх мэт уламжлалт олон нийтийн байгууллагууд зонхилж байна. Харин дээрх аймгуудтай харьцуулахад Дундговь аймагт иргэний нийгэм нь харьцангуй идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ч ТББ-ын үйл ажиллагааг тойрсон бэрхшээлтэй асуудлууд олон байна. Энэ аймагт 60 гаруй ТББ бүртгэлтэй байгаагаас идэвхтэй хэд хэдэн ТББ хамтран сүлжээ байгуулжээ. Дийлэнх нь тогтвортой, ажилладаггүй, боловсон хүчний ихэнх нь төрийн

байгууллагад давхар ажил эрхлэх зэрэг түгээмэл хүндрэл байсаар л байна. Тухайлбал, энэ аймгийн Хүүхдийн төлөө төв, театр, Аймгийн засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэс, эмнэлэгт ажил эрхэлж байгаа хүмүүс ТББ-ын ажлыг хавсарга байдлаар гүйцэтгэж байна.

ННФ-ын Мониторингийн чадавхи бэхжүүлэх сургалтад орон нутгийн ТББ-уудын нийт 100 гаруй хүн хамрагдсны зэрэгцээ тэдний гаргасан зарим санаачилгыг дэмжин хэд хэдэн байгууллагад мониторинг хийхэд нь

дэмжлэг үзүүлээ. Тухайлбал, Говьсүмбэр аймгийн Өмгөөлөгчдийн Зөвлөл, Хуульч Эмэгтэйчүүдийн холбоотой хамтран ажлаасаа үндэслэлгүй халагдсан иргэдийн асуудалд, Архангай аймгийн Хөдөөгийн Хөгжил Ундарга нийгэмлэг хог хаягдал зайлуулах үйлчилгээнд тус тус мониторинг хийж байна. ННФ цаашид орон нутгийн ТББ-уудын чадавхийг дэмжих зорилгын хүрээнд бусад ажлыг санаачлан хэрэгжүүлнэ.

### АЖЛААС ХАЛАГДСАН ИРГЭДИЙН ЭРХИЙН АСУУДЛААР ХИЙСЭН МОНИТОРИНГ

Төслийн хүрээнд 12 байгууллагын 85 ажилтанг халсан тушаалыг хуулбарлан авч танилцан хөдөлмөрийн хууль тогтоомж зөрчсөн байх магадлалтай 30 тохиолдлыг сонгон авч судалжээ. Ингэхэд:

Хөдөлмөрийн гэрээг цуцлахдаа ихэвчлэн ноцтой зөрчил гаргасан гэх ерөнхий үндэслэл дурдсан байх авч үнэн хэрэгтээ ихэвчлэн Хөдөлмөрийн гэрээ, байгууллагын дотоод журамд заагдаагүй үндэслэлээр ажлаас халсан (Хөдөлмөрийн хуулийн 40-р зүйлийн 40.1.4-т заасан шаардлагыг хангаагүй),

Хөдөлмөрийн гэрээ анхнаасаа байгуулаагүй (Хөдөлмөрийн хуулийн 24-р зүйлийн 24-1-ийг ноцтой зөрчсөн),

Бага цалинтай ажилд шилж эсвэл ажлаас халагд гэх зэрэг дарамт үзүүлэх

(Хөдөлмөрийн хуулийн 7-р зүйлийг зөрчсөн) зөрчил нийтлэг илэрсэн байна.

*Говьсүмбэр аймгийн Өмгөөлөгчдийн Зөвлөл*

## ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улс 2011-2013 онд Ардчилсан орнуудын хамтын нөхөрлөлийг тэргүүлэх нэр хүндтэй үүргийг хүлээж авсантай холбоотойгоор бүс нутагтаа төдийгүй, нөхөрлөлийн гишүүн орнуудад үлгэр жишээ болохуйц иргэний нийгмийн хөгжлийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилт тавин ажиллаж байна. ННФ энэ үйл явцыг дэмжин Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэх ХЗДХЯ-ны ажлын хэсэгт оролцон ажиллаж байгаагийн зэрэгцээ Монгол Улсын Засгийн газраас боловсруулж буй Иргэний нийгмийн хөгжлийг

дэмжих бодлогын баримт бичиг боловсруулах ажилд мөн хувь нэмрээ оруулж байна.

Иргэний нийгмийн эрх зүйн орчныг шинэчлэхэд хэд хэдэн чухал асуудалд зөв шийдэл олох сорилт тулгарч байна. Тухайлбал, Монголын төрийн бус байгууллагууд санхүүжилтийн хувьд олон улсын доноруудаас хараат байж ирснийг өөрчилж үйл ажиллагаагаа тогтвортой явуулах дотоодын санхүүжилтийн эх үүсвэр, механизмыг бий болгох, жишээлбэл, нийгэмд тустай үйл ажиллагаа явуулдаг



Их Богдын нуруу – Говь-Алтайн нурууны хамгийн өндөр уул. Баянхонгор аймгийн нутгийн төв хэсэгт оршдог. 50 орчим км үргэлжилдэг

байгууллагууд төсвөөс дэмжлэг авах бололцоог нээх, татвар, даатгалын тухай холбогдох хуулиудад иргэний нийгмийн байгууллагуудад хөнгөлөлт үзүүлэх талаар зохих өөрчлөлтийг тусгах, түүнчлэн ТББ-ын өөрийн хяналт, хариуцлага, ёс зүйн тогтолцоог хөгжүүлэх нь чухал байна.

ННФ 2011 онд иргэний нийгмийн төлөөлөл, бодлого боловсруулагчид болон бусад оролцогч талтай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулах замаар дээрх

асуудлаар нэгдсэн ойлголт бий болгох, олон улсын туршлага, сургамжаас үлгэр аван хэрэгжүүлэх боломжийг судлах ажлыг гүйцэтгэлээ. 2011 оны 4 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо “Төрөөс төрийн бус байгууллагуудад үзүүлэх санхүүгийн дэмжлэг, олон улсын туршлага, сургамж” сэдэвт олон улсын дугуй ширээний ярилцлага зохион байгуулав. Энэхүү арга хэмжээнд Унгар улсын Иргэний Нийгмийн Хөгжлийн Сангийн захирал Балазс Сатор, Европын Ашгийн Бус

Этгээдийн Хуулийн Төвийн мэргэжилтэн Катерина Хадзи-Мичева Еванс, Америкийн Ардчилалд Туслах Үндэсний Сангийн мэргэжилтэн Риота Жонен, Польшийн Орон Нутгийн Сангуудийн Холбооны захирал Андрезж Зависка, Эстоний Иргэний Нийгмийн Үндэсний Сангийн захирал Агу Лаиус, Болгарийн Ашгийн Бус Хуулийн Төвийн захирал Лубен Панов нарын экспертүүд оролцон иргэний нийгмийн байгууллагуудыг санхүүжүүлдэг механизмын талаар мэдээлэл солилцлоо.

### ИРГЭНИЙ НИЙГМИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГААС

Иргэний нийгэм нь төлөвшсөн улс төр, нийгмийн нөхцөл байдал нь манайхтай төстэй Төв, Зүүн Европын орнуудад төрөөс иргэний нийгмийн байгууллагад дэмжлэг үзүүлэх янз бүрийн механизмыг бий болгожээ. Тухайлбал, Хорват улсад Иргэний Нийгмийг Хөгжүүлэх Үндэсний Сан нь Хорватын үндэсний сугалаат хонжворын орлогоос санхүүжиж, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг санхүүжүүлдэг. Албанид иргэний нийгмийн байгууллагуудыг тэтгэлгээр хангах тусгай үүрэгтэй Иргэний Нийгмийн Дэмжлэгийн Төрийн Агентлаг байдаг (Албани улсын төсөвт ТББ-уудад зориулсан тогтмол төсөв байдаг). Эстонид Хорватын загварт үндэслэн ТББ-уудад тэтгэлэг олгодог сан байгуулжээ. Эдгээр байгууллагын хувьд шийдвэр гаргах гол эрх мэдлийг иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн удирдах зөвлөл нь эдэлдэг. Түүнчлэн зарим газар татвар төлөгчид улсад төлж буй татварынхаа нэг юмуу хоёр хувийг тодорхой төрийн бус байгууллагыг санхүүжүүлэхэд зориулахыг хуулиар зөвшөөрсөн аж.



Монголын хувьд яам, агентлаг, төрийн байгууллагуудын зүгээс иргэний нийгмийн байгууллагуудад тодорхой хэмжээний санхүүжилт олгон гэрээний үндсэн дээр хамтран ажиллах, ТББ-уудын төлөөллийг оролцуулсан зөвлөл байгуулж, үйл ажиллагааг нь санхүүжүүлэх гэх мэт санаачилга гарч байна. ТББ-уудад төсвөөс олгож байгаа шууд дэмжлэгийн хэмжээ жилээс

жилд ерөнхийдөө нэмэгдэж байгаа юм. Гэвч ТББ-уудад системтэйгээр, тэгш шударгаар санхүүжилт олгох, төсвийн хөрөнгөөр хийсэн ажлын явц, үр дүнг зохих ёсоор хянаж олон нийтэд мэдээлэх нь учир дутагдалтай байна.

Төрөөс ТББ-уудад шууд дэмжлэг үзүүлэхдээ хэдий хэмжээний санхүүжилтийг ямар зорилго, чиглэлийн хүрээнд зарцуулах,

хэрэгжүүлэх байгууллагыг хэрхэн сонгохыг ил тод байлгахын зэрэгцээ уг хөрөнгийг хэрхэн зарцуулж байгаад хяналт тавих, хариуцлага тооцох механизм нь тодорхой байх ёстой юм. Энэ нь төсвийн санхүүжилтийг үр дүнтэй, хариуцлагатай зарцуулах чухал хөшүүрэг төдийгүй иргэний нийгмийн тогтвортой хөгжлийг хангах нэг нөхцөл болдог ажээ.

## ИРГЭДИЙН ОРОЛЦОО БА МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

2011 оны 6 дугаар сард “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуулийг Монгол Улсын Их Хурлаас баталсан нь төрийн ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд гарсан томоохон дэвшил боллоо. ННФ энэхүү хуулийн агуулгыг олон улсын туршлагад үндэслэн сайжруулах, олон улсын экспертүүдийн санал, иргэний нийгмийн байр суурийг бодлого боловсруулагчдад хүргэх ажлыг 2011 оны эхний хагаст зохион байгууллаа. УИХ-ын Төрийн Байгуулалтын Байнгын Хороонд хандан хүсэлт гаргаснаар 2011 оны 5

дугаар сард хуулийн төслөөр нээлттэй сонголт зохион байгуулав. Олон Улсын Хууль, Ардчиллын төвийн экспертүүдээр хуулийн төсөлд үнэлгээ хийлгэн, санал зөвлөмжийг зохих талуудад хүргэлээ. ННФ 2012 онд хуулийн хэрэгжилтийг хангахад анхаарч ажиллахаар төлөвлөж байна.

2011 онд тохиосон бас нэг онцлох үйл явдал нь төрийн ил тод байдлыг хангахтай холбоотой олон улсын шинэ санаачилга Нээлттэй Засаглалын Түншлэл (Open Government Partnership)-д Монгол Улс нэгдсэн явдал юм. Энэ түншлэлд нэгдсэн

улсууд тодорхой амлалт авч, үүрэг хүлээдэг жишгийн дагуу Монгол Улс засаглалын ил тод байдлыг сайжруулах төлөвлөгөө боловсруулж буй бөгөөд ННФ энэ төлөвлөгөөнд тусгах саналыг боловсруулахаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Мэдээллийн ил тод байдлыг хангах, иргэд шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжийг нээсэн зарим ахиц дэвшил эрх зүйн хүрээнд гарч байна. 2011 онд УИХ-аас баталсан төсвийн тухай хуульд төсөвтэй холбоотой шийдвэр гаргахад иргэдийг заавал оролцуулах тухай тусдаа бүлэг багтсан бөгөөд орон нутагт иргэдийн төлөөлөгчдийн хурал, засаг даргын шийдвэрт иргэдийг оролцуулах тодорхой санал санаачилга гарч эхэлж байна. Гэвч шинээр баталсан хууль, журмыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын туршлага хомс, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд мэдээлэл дулимаг байгаагаас удаашрах хандлагатай байна. Иймээс ННФ 2011 онд нийт 9 аймагт иргэдийн оролцоо, шийдвэр гаргах үйл явцын ил тод байдлыг нэмэгдүүлэх

чиглэлээр ажилладаг орон нутгийн төрийн бус байгууллагад дэмжлэг үзүүлж тэтгэлэг олголоо. Тухайлбал, Дорнод аймгийн Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн Холбооны салбар зөвлөл Улс төрийн Боловсролын Академийн салбартай хамтран тус аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэг, зохион байгуулалт, үйл ажиллагааг илүү боловсронгуй болгох үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн бол Хөвсгөл аймгийн Эг-Үүр ТББ, Хөвсгөл-Эрдэм ТББ-ууд хамтран Иргэдийн төлөөлөгчдийн хурлын болон иргэний танхимын үйл ажиллагааг идэвхжүүлэх зарим санаачилгыг хэрэгжүүлжээ. Мөн ажлыг Төв аймагт Ажил олгогч эздийн “Бизнес” холбоо, Өвөрхангай аймагт Орон Нутгийн Санаачилга ТББ, ЛЭОС-ын салбар зөвлөлтэй хамтран, Дундговь аймагт ЛЭОС-ын салбар зөвлөл, Баянхонгор аймагт Хонгор Нутгийн Дуудлага ТББ, Дундговь аймагт Дундговь-Ардчилал клуб, Дархан –Уул аймагт НДЭХ-ийн салбар зөвлөл, Булган аймагт ЛЭОС-ийн салбар зөвлөл, Ховд аймгийн Эрдэнэ-Булган суманд

Бидний харгуй - Булганы ирээдүй ТББ амжилттай хэрэгжүүлж байна.

Эдгээр байгууллагын туршлага, мэдээллээ солилцох боломжийг олгох үүднээс “Хөдөөгийн хөгжилд иргэдийн оролцоо” сэдэвт уулзалтыг 2011 оны сүүлээр зохион байгуулж, орон нутагт иргэдийн оролцооны механизмыг бий болгох талаар гарсан ахиц дэвшил, хүндрэл бэрхшээл, цаашид иргэний нийгмийн зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцлээ. Уулзалтад ТББ-ын төлөөллөөс гадна Өвөрхангай, Дархан-Уул, Дундговь, Төв, Ховд, Булган, Баянхонгор, Дорнод, Хөвсгөл аймгийн иргэний танхим, нутгийн удирдлагын байгууллагын төлөөлөл оролцож санал бодлоо хуваалцав. Энэ чиглэлээр ажиллаж буй байгууллагуудад зориулан ННФ [http:// participation.forum.mn](http://participation.forum.mn) цахим хуудас нээж орон нутгийн иргэний танхимуудын журам, иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэг болон бусад эх сурвалж, баримт бичгийг байрлуулан ТББ-уудын гүйцэтгэж буй ажлын талаар мэдээлж байна.

## ИРГЭДИЙН ОРОЛЦОО-ИРЭЭДҮЙН ХӨГЖИЛ

Төслийн хүрээнд Өвөрхангай аймгийн Сант, Баянгол, Хархорин, Хужирт, Бат-Өлзий, Арвайхээр суманд сайн дурын 9-12 иргэнийг оролцуулан иргэдийн зөвлөл байгуулж орон нутагт хийгдэж буй тендерт хяналт тавих ажлыг хэрэгжүүлсэн байна. Иргэд ийнхүү зохион байгуулттайгаар хяналт тавьж эхэлсэн нь төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахад багагүй хувь нэмэр болж эхлэв. Тухайлбал, Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд баригдсан цэцэрлэгийн барилгыг улсын комист хүлээлгэн өгөхдөө мөөгөнцөрийг нь нуун өнгөлөн далдалсан байсныг илчлэн дахин завсар хийлгэсэн байна.

ЛЭОС-ын Өвөрхангай аймгийн салбар зөвлөл цаашид иргэдийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг улам боловсронгуй болгон орон нутагт шударга ёсыг бий болгох, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төсвийг үр ашигтай зарцуулахад нөлөө үзүүлэхийг зорьж байна.

### *ЛЭОС-ийн Өвөрхангай аймгийн салбар зөвлөл*

## СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ

“Стратегийн өмгөөлөл” төслийн хүрээнд таван ТББ-д тэтгэлэг үзүүлсэн бөгөөд эдгээрийн гурав нь 2011 онд үргэлжлэн хэрэгжлээ. Төслийн үр дүнг сийрүүлэн авч үзвэл:

*Зориг Сан: Шилжин суурьшсан иргэдийн эрхийн өмгөөлөл*

Хөдөө орон нутгаас шилжин суурьшсан иргэдийн бүртгэлтэй холбоотой бэрхшээлийг арилгах зорилготой уг төслийн хүрээнд нийслэлд 10 гаруй жил шилжилтийн бүртгэлгүй амьдарсан дөрвөн иргэний асуудлыг шийджээ.

Шилжилтийн бүртгэл хийлгээгүйн улмаас эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ авч чадахгүй байгаа нь бүртгэл хариуцсан төрийн байгууллагын хандлага, хүнд суртал болон иргэдийн өөрсдийн мэдээлэлгүй, мэдлэггүй байдлаас голчлон шалтгаалж буйг төслийн үр дүнд тогтоожээ.

*Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо: Хариуцлагатай эмч - Эрүүл иргэн*

Төслийн явцад иргэдийн эрүүл мэндийг хохироосон дөрвөн хэрэгт өмгөөлөл хийв. Эмнэлгийн

байгууллага, ажилтны буруутай үйлдлийн улмаас хохирсон иргэдийн хувьд хохирлоо тодорхойлуулах, нөхөн төлүүлэх, зөрчигдсэн эрхээ сэргээлгэхэд маш их бэрхшээлтэй тулгардаг төдийгүй мэргэжлийн хяналтын болон хуулийн байгууллагын дунд хаягдах, дарагдах, үл хайхрах нь түгээмэл байна. Түүнчлэн мөрдөн шалгах чиг үүрэг бүхий хуулийн ажилтнууд эмнэлгийн үйл ажиллагаатай холбоотой хэргийг шийдвэрлэх мэдлэг чадвар сул, шинжээчдийн дүгнэлт нь хараат, байцаан шийтгэх ажиллагаа бие даасан хараат бус байгаа нь төслийн явцад ажиглагдлаа.

*Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв: Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдэгчдэд ял оноох бодлого*

Төслийн хүрээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас өөрийгөө болон гэр бүлээ хамгаалах сэдлээр гэмт хэрэгт үйлдсэн хүмүүст өмгөөлөл үзүүлэх, ял хөнгөлөх жишиг тогтоох зорилготой стратегийн өмгөөллийг хэрэгжүүлж байна. Цагдаагийн байгууллага хохирогчдыг хамгаалалтад авдаг байх тухай гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хуулийн заалтыг

хэрэгжүүлэхийн зэрэгцээ гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн хэрэгт ялыг хөнгөрүүлэх шийдвэр гаргуулж чадсан нь томоохон ахиц боллоо. Түүнчлэн төслийн явцад олж авсан мэдээлэл, баримтыг ашиглан гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулахад оролцож байна.

*Монголын Байгаль Орчны Төлөөх Хуульчдын Холбоо: Ашигт малтмалын бүсэд оршин суудаг иргэдийн эрхийг шүүхээр хамгаалах нь*

Баянхонгор аймгийн Айраг суманд үйл ажиллагаа явуулж буй Монросцветмет нэгтгэлийн уурхайн нөхөн сэргээлтийг стандартын дагуу гүйцэтгүүлэх шаардлагыг хүргүүлснээр шүүхийн өмнөх шатанд нөхөн сэргээлт хийхээр болсон байна. Гэвч энэхүү эвлэрлийн гэрээний хэрэгжилт хууль эрх зүйн хувьд баталгаа багатай байна.

*Монголын Байгаль Хамгаалах Хөдөлгөөнүүдийн Эвсэл: Матад сумын иргэдийн эрх ашгийг хамгаалах нь*

БНХАУ-ын төрийн өмчит Петрочайна газрын тосны компанийн үйл ажиллагааны улмаас Дорнодын Матад сумын иргэдийн эрх ашиг хохирч байна гэсэн үндэслэлээр эхлүүлсэн энэ

төслийн хүрээнд тухайн нутгийн иргэдийн ашиг сонирхлыг хэрхэн зөрчиж байгааг баримтаар нотоллоо. Газрын тосны хайгуул, олборлолт ашиглалтыг зохицуулсан хууль эрх зүйн




орчин сул байгаагийн улмаас олон жилийн турш хайгуулын зөвшөөрлийн хүрээнд гадны хөрөнгө оруулагчид газрын тос олборлосоор байгаа ноцтой зөрчлийг илрүүлжээ. Төслийн багийнхан одоо

газрын тосны хайгуул, олборлолтын талаар бодлого, стандарт боловсруулах ажлын хэсэгт орж ажиллаж байна.

Дээрх төслүүдээс Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо,

Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв, Монголын Байгаль Хамгаалах Хөдөлгөөнүүдийн Эвсэл зэрэг байгууллагуудад ННФ тэтгэлэг үргэлжлүүлэн олгож дэмжлэг үзүүлээ.



Матадын хөндий - Дорнод аймгийн Матад сумын нутагт оршдог. Эндээс холгүй газар Хятадын Петрочайна компани зөвхөн хайгуулын зөвшөөрлөөр олборлолт явуулж байгааг ННФ-ын Стратегийн өмгөөллийн төслийн хүрээнд илрүүлсэн болно.

# ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Олон улсын Хил Хязгааргүй Сэтгүүлчид (Reporters Without Borders) байгууллагаас жил бүр гаргадаг хэвлэлийн эрх чөлөөний индексээр Монгол Улс 2011 онд өмнөх оноос 24 байраар ухарч 178 орноос 100-д жагсчээ. Түүнчлэн Freedom House олон улсын байгууллагаас жил бүр гаргадаг дээрхтэй төстэй индексээр Монгол Улс 2003 оноос эхлэн хэвлэлийн хагас эрх чөлөөтэй оронд тооцогдсоор ирсэн билээ. Үүнд нөлөөлж буй гол хүчин зүйл нь Иргэний болон Эрүүгийн хуулийн хүний нэр хүндэд халдах, гүтгэн доромжлохтой холбоотой заалтыг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын эсрэг ашиглах, улмаар хэвлэн нийтэлснийх нь төлөө сэтгүүлчдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, шүүхэд нэхэмжлэх, цагдан хорих, мэдээлэл авсан эх сурвалжаа илчлэхийг шаардах, айлган сүрдүүлэх, техник хэрэгсэлд нь халдах, хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөлөөр дамжин улс төрийн цензур тогтоох зэрэг болно. Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр Глоб Интернэшнл ТББ-аас хэрэгжүүлсэн “Хараат бус хэвлэл мэдээллийг дэмжих нь: Хэвлэлийн эрх чөлөөний мониторинг”-оор сэтгүүлчдийн эрхэнд

халдсан 29 тохиолдол бүртгэгджээ. Төслийн хүрээнд сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийг зөрчиж буй талаар шуурхай мэдээлэх, олон улсын сүлжээдэд мэдэгдэх, сэтгүүлчид эрх нь зөрчигдсөн тухайгаа ямарваа шат дамжлагагүйгээр өөрөө шууд мэдээлэх боломж бүхий цахим хуудас ажиллуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Сүүлийн 10 гаруй жил яригдсаар ирсэн хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах эрх зүйн орчны шинэчлэлийн асуудалд 2011 онд чухал ахиц гарлаа. Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг тус тусдаа боловсруулан УИХ-д өргөн барьж, улмаар тэдгээрийг нэгтгэн хэлэлцэхээр шийдвэрлэлээ. ННФ энэ хуулийн төслийг боловсруулах явцад сэтгүүлчдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг явдлыг халах, мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрхийг хуулиар нээх, хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөлийг ил тод болгох, хэвлэлийн өөрийгөө зохицуулах механизмыг нэвтрүүлэх зэрэг асуудалтай холбоотой мэдээллийг оролцогч талуудад

хүргэх, хэлэлцүүлэг, дугуй ширээний ярилцлага зохион байгуулах ажлыг зохион байгууллаа. 2011 оны 10 дугаар сард “Хүний нэр төр, алдар хүндийн эрх зүйн хамгаалалт” сэдвээр цуврал хэлэлцүүлэг, дугуй ширээний ярилцлагыг зохион байгуулав. Гол зорилго нь Эрүүгийн хуулийн 110 болон 111-д заасан доромжлох, гүтгэх гэмт хэргийн зүйлчлэлд нэмэлт оруулах замаар сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагын эсрэг дээрх заалтыг ашиглах явдлыг зогсооход оршиж байв.

Монголын Хэвлэлийн Хүрээлэнгийн “Монголын олон нийтийн телевизийн шилжилтийн үеийн хөтөлбөрийн бүтэц, мэдээ нэвтрүүлгийн агуулгын мониторинг-3” төсөлд ННФ 2011 онд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлээ. Төслийн хүрээнд олон нийтийн телевиз нь үнэн зөв, хараат бус, олон талт мэдээллийг түгээж, иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаатай хангах үүргээ хэрхэн гүйцэтгэж байгааг хэд хэдэн шалгуураар тогтоон олон нийтэд мэдээлэв.

# ЧӨЛӨӨТ ШУДАРГА СОНГУУЛЬ

2011 онд Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийг шинэчлэн баталлаа. Энэхүү шинэ хуульд сонгуулийн үйл явцыг ил тод, боловсронгуй болгоход чиглэсэн хэд хэдэн чухал заалт тусгалаа олсон юм. Ийм ахиц дэвшил гарахад ННФ-ын дэмжлэгээр байгуулагдсан иргэний нийгмийн сүлжээний 2008 оны УИХ-ын сонгуулийн үйл явцад хийсэн мониторинг, тэдгээрээс гарсан дүгнэлт, зөвлөмж болон ННФ-аас сүүлийн жилүүдэд тасралтгүй явуулж ирсэн үйл ажиллагаа багагүй үүрэг

гүйцэтгэсэн болно. Хуулийн төслийг хэлэлцэх явцад ННФ сонгуулийн хороодын томилгоо, үйл ажиллагааны ил тод байдал, сонгогчдын нэрийн жагсаалт гаргах үйл явцыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох, сонгуульд иргэний нийгмийн байгууллагууд хөндлөнгийн хяналт тавих бололцоог нээх, сонгуульд саналыг автоматаар тоолоход зайлшгүй анхаарах асуудлууд сэдвээр бодлогын цувралуудыг нийтлэн бодлого боловсруулагчид болон бусад сонирхогч талд хүргэлээ. Түүнчлэн 2011 оны эхээр

Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизтэй хамтран цуврал нэвтрүүлэг бэлтгэн олны хүртээл болгосон нь иргэдэд сонгуулийн явцад гардаг зөрчил, тэдгээрээс сэргийлэхийн тулд авах арга хэмжээний талаар тодорхой ойлголт өгсөн үр дүнтэй ажил боллоо. Мөн ННФ-ын хүсэлтээр УИХ-ын Төрийн Байгуулалтын Байнгын Хороо сонгуулийн хуулийн шинэчлэлийн талаар нээлттэй сонсгол зохион байгуулж холбогдох талуудын санал, байр суурийг сонссон юм.



## УИХ-ЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ШИНЭ ХУУЛИЙН СОНГУУЛИЙН ҮЙЛ ЯВЦТАЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ ОНЦЛОГ ЗААЛТУУД

Өмнөх сонгуулиар сонгогчдын саналыг хураах, тоолох үйл явцыг зөвхөн нам, эвсэл, нэр дэвшигчдийн томилсон ажиглагчид, түүнчлэн гадаадын байгууллагууд ажиглах боломжтой, харин дотоодын иргэний нийгмийн байгууллагуудын хувьд энэ үйл явц бүхэлдээ хаалттай байв. Сонгуулийн шинэ хуульд ТББ-уудын оролцоог хангахад чиглэсэн хоёр шинэ заалт орлоо. Тодруулбал, хуулийн 9.5.-д “Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах дүрмийн үүрэг, зорилт бүхий төрийн бус байгууллага нь Сонгуулийн Ерөнхий Хорооноос тогтоосон журмын дагуу сонгуулийн хороод, сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ / мониторинг/ хийх, сонгогчийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, эрхээ хэрэгжүүлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх зэргээр сонгуулийг хууль ёсоор хуулийн дагуу, шударгаар явуулахад туслалцаа үзүүлэх эрхтэй” гэж заасан ба хуулийн 44.9.-д “Дотоод, гадаадын байгууллага болон хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн явцыг ажиглах, сурвалжлахтай холбогдсон харилцааг энэ хуулийн 44.8-д заасан журмаар зохицуулна” гэжээ.

Сонгуулийн будлианы гол зэмсэг болж ирсэн гэгддэг сонгогчдын нэрийн жагсаалтад иргэний нийгмийн байгууллагууд анх удаа 2008 оны сонгуулиар мониторинг хийсэн. Энэхүү мониторингийн үр дүнд үндэслэн сонгогчдын бүртгэлийг улсын хэмжээнд нэгтгэн хаягийн давхцыг арилгах, нэрийн жагсаалтыг шинэчлэх асуудлыг системтэй, хяналттай болгох, түүнчлэн сонгуулийн хэсгийн хороод сонгогчдын нэрийн жагсаалтад тодорхой үндэслэл, хяналтгүйгээр дур зоргоороо өөрчлөлт хийдгийг халах зэрэг асуудлыг тусгасан зөвлөмж гаргасан билээ. Сонгуулийн шинэ хуульд уг зөвлөмжид багтсан саналаас дийлэнх нь тусгалаа олсон байна. Тухайлбал, сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний шинэчилсэн бүртгэлд үндэслэн улсын хэмжээнд нэгтгэн гаргах, шаардлагатай өөрчлөлтийг цаг тухайд нь оруулах үүргийг Улсын Бүртгэлийн Албанд бүхэлд нь хариуцуулж, сонгуулийн хэсгийн хороод дураараа өөрчлөлт оруулахыг хоригложээ.

Сонгуулийн чиглэлээр ажилладаг ТББ-уудын хувьд хуулийн эдгээр шинэ зохицуулалтууд нь сонгуулийн үйл явцад өмнөхөөс өргөн хүрээнд үр дүнтэй хяналт тавих цоо шинэ боломж нээхийн сацуу шинэ сорилтыг бас авчирч буй юм. Тухайлбал, сонгуульд ажиглалт хийх ТББ-ууд нөөц

бололцоогоо бүх талаар дайчлан сонгуулийн санал хураах, тоолох үйл явцад аль болох өргөн хүрээнд хөндлөнгийн хяналт тавьж прецедент тогтоох нь чухал байна. Түүнчлэн Сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой хуульд орсон өөрчлөлтийн үр дүнг бодитой хэмжихэд иргэний нийгмийн

зүгээс 2012 оны сонгуулийн үеэр дахин хяналт тавих нь чухал байна. ННФ энэ шинэ сорилтод ТББ-уудаа нэгтгэн зохион байгуулж бэлтгэх, улмаар 2012 онд төрийн бус байгууллагууд хөндлөнгөөс өргөн хүрээнд хяналт тавих ажлыг зохион байгуулахад анхаарч ажиллах юм.



# ЭДИЙН ЗАСГИЙН ХӨТӨЛБӨР

# ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд ННФ өмнөх онуудын нэгэн адил хүчин чармайлт гарган ажиллалаа. 2011 онд Монгол Улс ээлжит тайлангаа гаргаснаас гадна олон улсын нэр хүндтэй шагнал болох ОУИТБС-ын даргын нэрэмжит шагналыг хүлээн авсан бөгөөд үүнд иргэний нийгмийн оролцогчид, түүний дотор ННФ-ын хувь нэмэр их байлаа. Гэсэн хэдий ч ОУИТБС-ын хэрэгжилтийг улам бүр чанаржуулах, хамрах хүрээг нь өргөжүүлэх шаардлага байгаа тул ННФ 2011 онд онцгойлон анхаарч ажиллав. Тухайлбал, уул уурхайн үйл ажиллагаа нутаг оронд нь өрнөж буй сумдын хувьд ОУИТБС-ыг тусгайлан хэрэгжүүлэх боломж, нөхцлийг судлах зорилгоор Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сумдад төсөл хэрэгжүүлж, сумдын ОУИТБС-ын тайланг гаргаж хөндлөнгийн аудитын байгууллагаар хянуулах, олон талын оролцоот бүлэг байгуулан ажиллахад ННФ арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүллээ. Уг төслийн үр дүнд сумын тайланг тусад нь бэлтгэн гаргах нь төдийлөн оновчгүй, харин үндэсний хэмжээнд гарах тайланд сумдад төлөгдөж

буй төлбөрийг задлан харуулж, мэдээллийг сумдын иргэдэд хүргэх нь илүү оновчтой талаар зөвлөмж боловсрууллаа.

ОУИТБС-ыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох, тухайлбал, ОУИТБС-ын тухай тусгайлан хууль гаргах чиглэлээр бусад оролцогч тал, Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны төслийн баг, ОУИТБС-ын Ажлын албатай удаа дараа санал солилцож дэмжлэг үзүүллээ. Түүнчлэн ОУИТБС нь төр засаг компани хоёрын хооронд хийгдэж байгаа төлбөрийг л хамраж байгааг цаашид өргөжүүлэх, тухайлбал уул уурхай, газрын тосны чиглэлээр байгуулагдаж буй гэрээ хэлэлцээр, мөн лиценз зөвшөөрлийг хамруулах оролдлогыг хийж буй ч одоогоор хангалттай үр дүнд хүрч чадаагүй байна.

Олон улсын түвшинд нийт 35 улс орон ОУИТБС-ыг хэрэгжүүлж байгаа ба тус байгууллагын олон улсын удирдах хороонд иргэний нийгмийг төлөөлж ННФ-ын менежер хоёр жилийн хугацаатай ажиллаж эхлэв. Иргэний нийгмийн байр суурийг олон улсын хорооны шийдвэр гаргах явцад

илэрхийлэхээс гадна ОУИТБС-ын Санхүүгийн асуудал эрхэлсэн хороонд гишүүнээр ажиллаж байна.

ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийг голлон төлөөлж буй “Төлсөн Авснаа Нийтэл” буюу ТАН эвслийн үйл ажиллагааг ННФ 2011



онд удирдан зохицуулж, бүх талын дэмжлэг үзүүлээ. ТАН эвслийн гишүүдийг ОУИТБС-ын тухай болон бусад холбогдох мэдээллээр байнга ханган чадавхи бэхжүүлэх сургалтуудад хамрууллаа. Тухайлбал, Орлогын Ажиглагч Хүрээлэнгийн зохион байгуулсан

“Уул уурхайн орлогын менежмент”, “Орлогын менежментийн мониторинг” сэдэвт сургалтуудад эвслийн гишүүн байгууллагууд оролцсон бөгөөд цаашид иргэний нийгмийн төлөөлөлд зориулан сургалт явуулах сургагч багш нарыг бэлтгэлээ. Түүнчлэн Кавказ, Евро-

Азийн бүс нутгийн иргэний нийгмийн байгууллагуудын ээлжит уулзалтад оролцож туршлага солилцлоо. ТАН эвслийн зохицуулагчийн үүрэг 2011 оны эцсээр ННФ-аас Хил Хязгааргүй Алхам төрийн бус байгууллагад шилжсэн болно.



Үүртийн тохой - Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын төвөөс зүүн хойш 18 км-ын зайд орших Орхоны эгц цавчим хавцалд оршдог, нүүрсхүчлийн хийтэй, исгэлэн хүйтэн рашаантай. Түүнийг нь ууж эмчилгээнд хэрэглэдэг. Тул загас хөвж байгаа нь энэ нэвт харагддаг байсан энэ гол сүүлийн жилүүдэд уул уурхайн олборлолтын улмаас ийнхүү улаан шороогоор урсдаг болжээ.

# ОЛБОРЛОХ САЛБАРЫН БОДЛОГЫН АСУУДЛУУД

ННФ олборлох салбараас орох орлогын удирдлагыг боловсронгуй болгоход бодлого боловсруулагчдын анхаарлыг хандуулахад анхаарч ажиллалаа. Орлогын менежментийн асуудал, тэр тусмаа нөхөгдөшгүй баялаг болох эрдэс баялгийн салбараас орж буй орлогыг зохистой, үр өгөөжтэй зарцуулахад иргэдийн анхаарлыг хандуулах, оролцох боломжийг өргөтгөх зорилгоор Монгол Улсын орлогын менежментийн асуудлаарх эдийн засгийн сценари боловсруулах ажлыг ННФ 2011 онд санаачлан зохион байгууллаа. /Дэлгэрэнгүйг “Эдийн засгийн

хөгжлийн дүн шинжилгээ” хэсгээс үзнэ үү/.

Уул уурхайн орлогын менежментийн институцийг бэхжүүлэх, хөндлөнгийн үнэлгээ өгөх, бодлогын шийдлүүдийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор эдийн засгийн төрөлжилт болон орлогын менежментийн бодлогын мониторингийг Орлогын Ажиглагч Хүрээлэнгийн аргачлалын дагуу эхлүүлээ. Тус хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр мониторингийн арга зүйн сургалтыг хоёр удаа зохион явуулж, судалгааг хамтран хийх болон төр

засгийн бусад байгууллагын төлөөлөгчдийг оролцуулав. Орлогын менежмент, эдийн засгийн төрөлжилтийн мониторингийн мэдээлэл цуглуулах ажлыг 2011 онд хийсэн ба мониторингийн үр дүн 2012 оны эхний хагаст гарах юм.

Түүнчлэн уул уурхайн төслийн эдийн засгийн үнэлгээ, орлогын менежментийн асуудлаар АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн дэмжлэгтэйгээр төрийн болон судалгааны байгууллагуудын мэргэжилтнүүдэд зориулж сургалт зохион байгуулан чадавхийг дээшлүүлээ.



Гар аргаар алт олборлогчид

# ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Нээлттэй Нийгэм Форум “Төсвийн бодлогын нээлттэй, ил тод байдлыг дэмжих нь” төслийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бэхжүүлэх асуудалд анхаарал хандуулан тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэж байна. 2011 онд төсвийн харилцааг зохицуулдаг “Нэгдсэн төсвийн тухай” болон “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулиудыг хүчингүй болгож, Төсвийн тухай хуулийг УИХ-аар шинэчлэн баталсантай холбогдуулан төсвийн ил тод байдал, иргэдийн оролцоог хангах, хариуцлагыг бэхжүүлэх нөхцлийг бүрдүүлэх үйл ажиллагааг ННФ бусад түнш байгууллагатай хамтран хэрэгжүүлээ.

Орон нутгийн төсвийн мэдээллийн ил тод байдлыг хангах, төсөв боловсруулах болон хэрэгжүүлэх, хянах үйл явцад иргэд оролцох боломж бүрэлдсэн эсэхэд дүн шинжилгээ хийх зорилгоор “Орон нутгийн төсвийн ил тод байдлын индекс-2011”-г анх удаа хөндлөнгийн байр сууринаас боловсруулан гаргалаа. Монгол Улсын бүх аймаг, нийслэлийг хамруулсан тусгай асуулгын дүнг нэгтгэхэд орон нутгийн

төсвийн ил тод байдлын түвшин хангалтгүй буюу орон нутгийн засаг захиргаа төсвийн ил тод, нээлттэй байдлаараа авч болох дээд онооны 34 орчим хувийг л дунджаар авсан байв. Судалгааны үр дүнд орон нутгийн төсвийн ил тод байдлыг сайжруулах эрх зүйн орчныг бэхжүүлэх, сайн туршлагаудыг хэрэгжүүлж хэвших талаар зөвлөмж гарган бодлого боловсруулагчид болон олон нийтэд танилцууллаа. Судалгааны аргачлалыг олон улсын туршлагад тулгуурлан боловсруулсан агаад үр дүнг Нээлттэй Төсвийн Түншлэл байгууллагын хамтрагчдад мөн хүргүүллээ. Судалгааны үр дүн, зөвлөмжийг төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангахад чиглэсэн хуулийн заалт, журам боловсруулах үүрэгтэй ажлын хэсэгт хүргэлээ. Цаашид судалгааг хоёр жилд нэг удаа тогтмол явуулах юм.

Төсвийн ил тод байдлыг хангах, төсвийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилго бүхий “Иргэд Төсвөө Хянана” сүлжээний үйл ажиллагааг дэмжиж ажиллалаа. Уг сүлжээний гишүүн байгууллагууд 2011 онд орон нутгийн төсвийн ил тод байдалд мониторинг хийсний

зэрэгцээ “Орон нутгийн төсвийн ил тод байдлын индекс”-ийг гаргахад оролцлоо. Орон нутгийн төсвийн төслийг нийслэл, дүүрэг, зарим аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэх явцад мониторинг хийж хэлэлцүүлэг зохион байгуулав. Мөн Авилгатай Тэмцэх Газраас Сүхбаатар, Баянхонгор, Увс аймагт зохион байгуулсан төрийн үйлчилгээний мониторингийн сургалтад сүлжээний гишүүд оролцож, төсвийн мониторинг хэрхэн хийх талаар хичээл заав. ХХААХҮЯ, нийслэлийн Чингэлтэй дүүргийн төсвийн зарцуулалт, нийтийн тээврийн автобусны худалдан авалт, нийслэлийн 1 ба 2-р төрөх эмнэлгийн засвар зэрэгт мониторинг хийхэд оролцлоо. Мониторингийн үр дүнд тулгуурлан төсвийн тухай хуулийн төсөл болон төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах журмын төслийг батлагдахаас нь өмнө удаа дараа хэлэлцүүлэг хийн иргэний нийгмийн байр суурийг бодлого боловсруулагчдад хүргэлээ. “Иргэд Төсвөө Хянана” сүлжээний чадавхийг бэхжүүлэх үүднээс Сангийн яамнаас зохион байгуулдаг, худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ

сертификатын ээлжит сургалтад сүлжээний гишүүдийг хамруулснаар тэднийг тендерийн үнэлгээний хороонд оролцох боломжийг нээсэн болно.

ННФ 2011 онд шинээр зарлагдсан Төсвийн Ил Тод Байдлын Даян Дэлхийн санаачилгад нэгдэж, олон улсын төсвийн ил тод, нээлттэй байдлын стандартууд, шилдэг туршлагыг Монголд хэрэгжүүлж ажиллах

бололцоотой боллоо. Орлогын Ажиглагч Хүрээлэнгээс зохион байгуулсан уул уурхайн орлогын удирдлагад мониторинг хийх тусгайлсан сургалтад дээрх сүлжээний гишүүд хамрагдсан төдийгүй гадаадын ижил төстэй иргэний нийгмийн байгууллагуудын туршлагыг судлах зорилгоор Төсвийн Ил Тод Байдлын Даян Дэлхийн Санаачилгын хуралдаанд оролцов.

Олон Улсын Төсвийн Хамтын Ажиллагаа байгууллагаас хоёр жил тутамд гаргадаг судалгааг ННФ 2011 онд хийж гүйцэтгэн Монгол Улсын төсвийн ил тод, нээлттэй байдлыг бусад улс оронтой харьцуулан судаллаа. Энэ бол төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд онцгой ач холбогдолтой, бодлого боловсруулагчдын дунд хүлээн зөвшөөрөгдсөн судалгаа юм. Судалгааны дүн 2012 онд нэгтгэгдэн гарна.



Тэрхийн цагаан нуур - Архангай аймгийн Тариат сумын нутагт Хоргын тогооны дэргэд байрлах цэнгэг уст нуур. Хамгийн өргөн газраа 6 км хүрдэг, урт нь 16 км бөгөөд усны түвшин нь 2060 м. 10 гаруй гол цутгадаг. Энэ нуурыг 2011 онд CNN мэдээллийн төв аялах шилдэг газруудын нэгэнд багтаажээ.

# ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эдийн засгийн хөтөлбөрийн хүрээнд 2011 онд эхлүүлсэн нэг томоохон ажил бол орлогын менежментийн асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах, нөхөгдөшгүй баялаг болох эрдэс баялгийн салбараас орж буй орлогыг зохистой, үр өгөөжтэй зарцуулахад иргэдийн оролцох боломжийг өргөтгөх, бодлого боловсруулагчдад нөлөөлөх зорилгоор Монгол Улсын орлогын менежментийн асуудлаарх эдийн засгийн сценари боловсруулах явдал байлаа. Уул уурхайн салбарын орлогын хуваарилалт, менежмент нь зөвхөн бодлого боловсруулагчид төдийгүй олон нийтийн анхаарлыг татсан асуудал болж байгаа өнөө үед хуримтлагдсан мэдээ мэдээллийг цэгцлэн, мэдлэг, мэдээлэл харьцангуй өндөртэй хүмүүсийн оролцоонд тулгуурлан энэ салбарын орлогын менежментийн ирээдүйн дүр зургийг боловсруулахад төслийн гол зорилго оршсон юм. Ийнхүү одоо хэрэгжүүлж буй болон цаашид хэрэгжүүлэх бодлого ямар байхаас шалтгаалан Монголын ирээдүйн зураглалыг боловсруулснаар хүссэн хөгжилдөө хүрэхийн

тулд юунд голлон анхаарах ёстойг мэдэж авах юм.

“2021 оны Монголын зураглал” сценарийн дөрвөн хувилбарыг ННФ өмнөх туршлагадаа тулгуурлан дотоодын болон олон улсын экспертүүдийн хамтын ажиллагааны тусламжтайгаар боловсруулсан бөгөөд эдгээрийг богино хэмжээний видео, баримтат кино хийх, сонин, сэтгүүл болгон хэвлэх замаар олон нийтэд хүргэх юм.

ННФ 2011 онд “Цахилгаан Эрчим Хүчний Засаглалын Санаачилга”-д (ЦЭХЗС) нэгдэж, энэхүү санаачилгыг Монголд хэрэгжүүлж эхэлсэн нь бас нэг шинэлэг ажил байлаа. ЦЭХЗС нь иргэний нийгэм, бодлого боловсруулагчид, зохицуулах байгууллагууд болон цахилгаан эрчим хүчний салбарын бусад төлөөлөл хамтран нийгэм, эдийн засгийн хувьд тогтвортой эрчим хүчний ирээдүйн салшгүй нэгэн хэсэг болох нээлттэй, ил тод, хариуцлагатай шийдвэр гаргах үйл явцыг бий болгох зорилгоор хэрэгжүүлж буй олон улсын санаачилга юм. Санаачилгын хүрээнд эрчим хүчний засаглалын судалгааг Дэлхийн Нөөцийн Хүрээлэн

болон Прайас Энержи Групп-ийн тусламжтай хэрэгжүүлж байна. Судалгаа нь цахилгаан эрчим хүчний салбарын гол шинж чанаруудын талаарх суурь судалгаа, сайн засаглалыг үнэлэх 64 асуулт бүхий үзүүлэлтээс бүрддэг. Эдгээр үзүүлэлт нь кейс судалгаа, бодлогын болон хууль, эрх зүйн баримт бичиг, албаны болон иргэний нийгмийн төлөөлөлтэй тусгайлан хийх ярилцлага зэрэгт тулгуурлан шийдвэр гаргах үйл явцыг үнэлдэг. Цахилгаан эрчим хүчний салбарт тулгарч буй нийгэм, байгаль орчин, эдийн засгийн сорилтуудад засаглалын үнэлэмжээр хандах нь асуудлыг шийдвэрлэх шинэ боломж юм.

Эрчим хүчний засаглалын судалгаагаар олон нийтийн оролцоонд тулгуурласан, тэдний эрх ашгийн төлөө хариуцлагатай өөрчлөлт хийх бүтэц, институцийн чадавхи бий эсэх, нэг үгээр хэлбэл эрчим хүчний салбарын засаглалын үнэлгээг хийхийг зорьж байна. Судалгааны тайланд Монгол Улсын эрчим хүчний салбарын тойм мэдээлэл, эрчмийн үйлдвэрлэл болон хэрэглээ, хөгжлийн стратеги, санхүү, эдийн засгийн төлөв

байдал, бүтцийн шинэчлэл, бодлогын болон хууль эрх зүйн зохицуулалтыг тайлбарласан бүлэг орж байгаа юм. Судалгааны үр дүн, зөвлөмжийг нээлттэй ярилцлага, хэлэлцүүлэг өрнүүлэх замаар бодлого боловсруулагчид болон олон нийтэд хүргэнэ.

Нээлттэй Нийгэм Форум 2011 оны 11 дүгээр сард Үндэсний Хөгжил, Шинэтгэлийн Хороотой хамтран Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох “Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2012-2016 оны тэргүүлэх чиглэлийн төсөл”-ийг хэлэлцүүлэх уулзалтыг эрдэмтэн судачид, иргэний нийгмийн төлөөлөгчид,

бодлого шийдвэрийг тодорхойлогчдын саналыг авах зорилгоор зохион байгууллаа.

2009 онд ННФ-аас санаачлан хэрэгжүүлж эхэлсэн “Хэрэглэгчийн итгэлийн индекс” судалгааг 2010, 2011 онд Санхүүгийн Зах Зээлийн Холбоотой хамтран “Хэрэглэгчийн хүлээлтийн индекс” /ХХИ/ нэртэйгээр үргэлжлүүлэн хийлээ. Хэрэглэгчийн хүлээлтийн индекс нь хэрэглэгчдийн хэрэглээний хандлагад гарч байгаа өөрчлөлт, инфляц, ажилгүйдэл, банкны секторын талаарх хэрэглэгчдийн байр суурь, Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх нийгмийн байр суурь гэсэн

таван чиглэлээр хэрэглэгчид ирээдүйд ямар хүлээлттэй байгааг тодруулах зорилго агуулдаг. ХХИ-ийг Монгол Улсын эдийн засгийн бүтцэд тохируулан улирал тутамд нэг удаа, статистик түүврийн аргаар сонгосон өрх, гэр бүлийг төлөөлөх 1000 хүнээс санал асуулга авах замаар тооцож байна. 2011 онд манай орны санхүү, эдийн засгийн байдал сайжирч, энэ нь өрхүүдийн хэрэглээнд эерэгээр нөлөөлөх болсныг хэрэглэгчийн хүлээлтийн индексийн дүн харуулж байна. Судалгааны үр дүнг улирал тутам өдөр тутмын сонинуудаар дамжуулан мэдээллээ.

### ХЭРЭГЛЭГЧИЙН ХҮЛЭЭЛТИЙН ИНДЕКС

|            |        |
|------------|--------|
| 1-р улирал | 229.12 |
| 2-р улирал | 199.70 |
| 3-р улирал | 203.78 |

ХХИ-ийн өсөлт эдийн засагт гарч байгаа эерэг өөрчлөлтөөр тайлбарлагдахаас гадна ажилгүйдэл буурч, төсвийн ажилчдын цалин тэтгэвэр нэмэгдэх болсон нь амьжиргаа сайжирна гэсэн хүлээлт байгааг харуулж байна.



### СУДАЛГААНЫ ДҮНГЭЭС:

|   |           |
|---|-----------|
| Өнөөгийн нөхцөл байдлын индикатор                       | 54.7      |
| Ирээдүйн төлөв байдлын индикатор                        | 73.4      |
| Сүүлийн нэг жилд санхүүгийн нөхцөл байдал өөрчлөгдөөгүй | 57.4%     |
| Өргөн хэрэглэгддэг барааны үнэ өссөн                    | 91%       |
| Монголын банкууд:                                       |           |
| найдвартай  | 29%       |
| найдваргүй  | 17%       |
| мэдэхгүй  | 54%       |
| Хуримтлалаа хэрхэн байршуулбал зохистой вэ?             |           |
| Үл хөдлөх хөрөнгө худалдаж авна (орон сууц)             | 50% (30%) |
| Банкинд хадгална (төгрөгөөр)                            | 38% (25%) |
| Хуримтлалаа хэрхэн байршуулсан бэ? – Банкинд төгрөгөөр  | 68%       |

# БИЗНЕСИЙН ОРЧИН

Дэлхийн Эдийн Засгийн Форумаас жил бүр улс орнуудын өрсөлдөх чадварын тайланг гаргадаг. Нээлттэй Нийгэм Форум “Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан”-д оруулах Монгол Улсын судалгааг Хүман Фортис Консалтанси компанитай долоо дахь

жилдээ хамтран гүйцэтгэлээ. Улс орнуудын өрсөлдөх чадварын индексийг нийт 12 бүлэгт хуваагдах 110 үзүүлэлтээр тооцдог ба тайлангийн гол хэсэг болох бизнесийн удирдах ажилтны санаа бодлын судалгааг түүвэрлэж сонгосон 80 компанийн удирдах түвшний

албан тушаалтнуудаас авлаа. Энэхүү индексээр тухайн улсын өрсөлдөх чадварт тулгарч буй асуудал, бэрхшээл болон давуу, сул талыг гаргаж ирдэг бөгөөд энэ удаад Монгол Улсын байр урагшаа ахиж дэлхийн нийт 142 улсаас 96 дугаарт жагссан байна.

## ДЭЛХИЙ ДАХИНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ТАЙЛАН ДАХЬ МОНГОЛ УЛСЫН БАЙР СУУРЬ

Манай Улсын хувьд байр суурь урагш ахихад гол алхам болсон үзүүлэлтүүд нь макро эдийн засгийн орчин (+15), түүн дотроо улсын төсвийн ашиг/алдагдал (+78), засгийн газрын өр (+17), бараа бүтээгдэхүүний зах зээлийн үр ашигтай байдал (+7), үүн дотор татвар ногдуулалтын хамрах хүрээ ба үр нөлөө (+21), гадаадын өмчлөлийн эзлэх хувь (+14), худалдан авагчийн боловсронгуй байдал (+18), бизнесийн боловсронгуй байдал (+8), энэ дотроо дотоодын нийлүүлэгчдийн тоо (+10), маркетингийн цар хүрээг (+7) зэрэг байна. Тухайлбал, улсын төсвийн алдагдал ДНБ-ий 5.4 хувь байсан бол 2010 онд 1.2 хувийн ашигтай гарч 78-р байрнаас 17-д орсон бол, засгийн газрын өрийн хэмжээ ДНБ-ий 26.9 хувиас 20.3 хувь болон буурснаар энэхүү үзүүлэлтээр манай улсын эзлэх байр 42-оос 25-д орж даруй 17 байраар урагш ахисан байна.

Монгол Улс шүүхийн хараат бус байдал, төсвийн зарлагын үрэлгэн байдал, дэд бүтэц болон санхүүгийн зах зээлийн хөгжлийн ихэнх үзүүлэлтээр тун хангалтгүй буюу 120-оос хойш байр эзэлсээр байгаа нь энэ асуудалд төр, засаг дорвитой арга хэмжээ авч бодлогын эрс шинэтгэл хийх шаардлагатай байгааг харуулж байна.

Уг судалгааны санал асуулга нь аливаа эдийн засгийн бизнесийн уур амьсгалд нөлөөлдөг олон янзын, өргөн хүрээтэй хүчин зүйлсийг хамруулдаг бөгөөд уг тайланд

улс орнуудын гол давуу ба сул талуудын дэлгэрэнгүй жагсаалтыг оруулж өгдөг нь бодлогын шинэтгэлийн тэргүүлэх чиглэлүүдээ тодорхойлох боломж олгодог.

ННФ судалгааны үр дүн, зэрэглэлийг олон нийт, шийдвэр гаргагчид болон холбогдох талуудад хүргэлээ.

# ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

Нээлттэй Нийгэм Форум 2009 оноос эхлэн олон улсын экспертийн тусламжтайгаар Бүсийн Хөгжлийн Санаачилга ТББ-тай хамтран “Орон нутгийн төсвийн орлогын хуваарилалтыг зохистой хангах нь”, “Орон

нутгийн төсвийн зарлагын шинжилгээ” судалгаануудыг хийн төсвийн төвлөрлийг сааруулах бодлогын шинэтгэлийн ажилд идэвхитэй оролцож байна. Тухайлбал, Ерөнхийлөгчийн Тамгын Газраас байгуулсан ажлын

хэсэгт ННФ-ын төлөөлөл орж ажилласны зэрэгцээ “Төсвийн харилцааны шинэтгэлийн зарим асуудал” сэдвээр бодлогын зөвлөмжийг боловсруулав.



Баянхонгор аймгийн Гурван булаг сум.

Түүнчлэн ННФ-аас зохин байгуулсан уулзалт хэлэлцүүлэг, үндэсний хэмжээний форумаас гаргасан зарим санал, санаачилга Төсвийн тухай хуулинд тусгалаа оллоо. Тухайлбал, уг хуулинд ННФ-

ын санал болгосон орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан байгуулах заалт орсон бөгөөд уг сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, хүн

амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, орон нутгийн татварын идэвхи санаачилга зэрэг итгэлцүүрүүдийг тооцохоор болсон юм.



Баянхонгор аймгийн Гурван булаг сум. Монголын засаг захиргааны нэгж болох сумдын ерөнхий байдал хоорондоо тун төстэй

**НИЙГЭМ, БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР**

# НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

ННФ-ын дэмжлэгтэйгээр 2011 онд Баянхонгор, Увс, Баян-Өлгий аймаг, Улаанбаатар хотын таван төрийн бус байгууллага нийгмийн халамж, нийгмийн хамгаалал, боловсролын

бодлогын хэрэгжилтэнд мониторинг хийлээ. Эдгээр нь ННФ-ын иргэний нийгмийг чадавхижуулах, орон нутагт нийгмийн бодлогын үр нөлөөг сайжруулах зорилгын хүрээнд хэрэгжсэн бөгөөд

төрийн бус байгууллагуудад судалгааны арга зүйг таниулах, төсөл хэрэгжүүлэх тэтгэлэг олгох, ажлыг нь удирдан чиглүүлэх зэрэг дэмжлэг үзүүлэв.

## ТӨСЛҮҮДИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Увс аймгийн “Сайн Тус” төрийн бус байгууллага олон нийтэд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээтэй холбоотой шийдвэр гаргах үйл явцын ил тод, нээлттэй байдалд мониторинг хийлээ. Уг төслийг хэрэгжүүлэхэд аймгийн ЗДТГ, Амьжиргааг дэмжих зөвлөл, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс маш идэвхтэй хамтран ажиллаж мэдээллээр хангасны зэрэгцээ хуралдаанд ажиглалт хийж оролцох боломж олгожээ. Мониторингийн үр дүнд Улаангом суманд байгууллага олон нийтэд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлж буй таван байгууллагыг сонгохдоо хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлан шалгаруулах бус, харин хүсэлт ирүүлсэн байгууллагатай шууд гэрээ байгуулсан нь тогтоогджээ. Гэрээт байгууллагын үйлчилгээнд хяналт тавьдаггүй, ирүүлсэн тайланд нь үндэслэн ажлыг нь дүгнэдгийг тогтоосон байна.

Ийм үйлчилгээг хувь хүн үзүүлж болох ч одоогоор иргэдээс тийм санал санаачилга гараагүй байна.

Баян-Өлгийн аймгийн “Урианхай, Дөрвөд, Тува Иргэдийн Нийгмийн Хөгжлийг Дэмжих холбоо” ТББ-аас тус аймгийн Цэнгэл сумын тува бага сургуульд түшиглэн хэлний цөөнхийн хүүхдүүдэд хос хэлний сургалтыг хэрхэн зохион байгуулж буйд мониторинг хийлээ. 2005 онд Хөвсгөл аймагт хийсэн судалгаагаар “25 хүртэлх насны цаатан хүмүүс тува хэлээ бараг мэдэхгүй байна” гэсэн дүгнэлт гарсанд үндэслэн БСШУ-ны Сайдын 387 тоот тушаалаар “Тува хэлний сургалтын хөтөлбөр” батлагджээ. Энэ хөтөлбөр нь хэлний прагматик, хэрэглээний талыг чухалчилж, тува хэлээр харилцах үр чадвар хөгжүүлэх зорилготой хөтөлбөр тул энэ хэлээр байнга харилцдаг, монгол хэл бараг мэддэггүй Баян-

Өлгий аймгийн Цэнгэл сумын тува хүүхдүүдийн хэрэгцээнд нийцэхгүй байгааг мониторингоор тогтоожээ. Үндсэн сурах бичгийн ихэнх нь Оросын Тувагаас тусламжийн шугамаар ирсэн ном бөгөөд үгсийн сангийн бүрдлийн хувьд эдгээр хүүхдийн төрөлх тува хэлнээс 50 орчим хувиар ялгаатай байна. Иймээс тува хүүхдийн суурь боловсрол олж мэдлэг мэргэжил эзэмших эрхийг хэрэгжүүлэхийн тулд монгол, тува хос хэлний стандарт бий болгон сурах бичиг, мэргэшсэн багшаар хангах ажлыг төрийн бодлогоор зохион байгуулахгүй бол Цэнгэл сумын тува хүүхдүүд тавдугаар ангиа төгсөөд аймгийн төвийн монгол сургууль, эсвэл сумандаа казак дунд сургуульд үргэлжүүлэн суралцахад сурлагаар хоцрох, хоёр анги ухарч сурахад хүрч байгааг мониторингийн тайланд дурджээ.

“Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Чөлөөт Үйлдвэрчний Эвлэл”-ийн Увс, Баянхонгор аймаг дахь салбар зөвлөлүүд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүдийн уялдаа холбоо, нөлөөг судлах

ажлыг хийж гүйцэтгэлээ. Юуны өмнө ажил олгогч эзэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг авч ажиллуулах нь тэдний нийгмийн өмнө хүлээж буй хариуцлага хэмээн ойлгож хандаж байгаа нь нийгмийн сэтгэл зүй, хандлагад гарч буй томоохон эерэг өөрчлөлт юм. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тодорхой ажлын байрт нийцүүлэн сургах шаардлага гарч байгаа тул “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын тухай” хуулийн 4.1.7 дугаар заалтын хэрэгжилтийг зохион байгуулах тулгамдсан хэрэгцээ үүсч байгааг судалгаагаар тогтоожээ.

“Хөгжлийн Бэрхшээлтэй Эмэгтэйчүүдийн Эрхийн Үндэсний Төв” ТББ байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүнийг асарч байгаа хүнд төрөөс олгодог мөнгөн дэмжлэгийн хүрэлцээг судаллаа. Сонгинохайрхан дүүргийн таван өрхийн жишээн дээр байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ асарч байгаа хүн өдрийг бүхэлд нь түүнд зориулж байгаа тул өөр хөдөлмөр эрхлэх, цагийн ажил хийх, гэрээр ажиллах зэргээр нэмэлт орлого олох боломжгүй

болохыг харуулсан байна. Гэтэл өнөөдөр үйлчилж буй хууль тогтоомжоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон насанд хүрсэн хүнийг гэртээ асардаг хөдөлмөрийн насны ажил эрхэлдэггүй иргэнд асаргааны тэтгэвэрт 31200 төгрөг олгож байна. Судалгаанд хамруулсан өрхүүдийн дотор хөгжлийн бэрхшээлтэй хоёр асруулагчтай өрхүүд тохиолдлоор багтсан бөгөөд асрагч нь сард мөн л 31200 төгрөгийг гурван хүнд хүргэх шаардлагатай болж байгаа нь эдгээр өрх нэн ядуу амьдарч байгаагийн шалтгаан болж байна. Иймээс гэртээ хүн асраад өөр ажил, хөдөлмөр эрхлэх боломжгүй хүмүүст олгож буй асаргааны тэтгэврийн хэмжээг наад зах нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүртэл нэмэгдүүлэх хэрэгтэй байгааг тайланд дурджээ.

Эдгээр төслийг хэрэгжүүлэхэд нь дээрх таван байгууллагад туслах зорилгоор төрийн үйлчилгээний мониторинг хийж байсан туршлагатай “Хил Хязгааргүй Алхам”, “Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Бизнес Инкубатор Төв” ТББ-уудыг зөвлөх байгууллагаар ажиллуулж дэмжлэг үзүүлсэн нь үр дүнд хүрлээ.

# БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

Монгол Улс боловсролын салбарын хөгжилд тууштай анхаарч, урсгал болон хөрөнгө оруулалтын зардалд нь нэлээд хөрөнгө зарцуулж байгаа хэдий ч өнөөгийн байдлаар эмзэг болон онцгой хэрэгцээ бүхий бүлгүүдэд чиглэсэн боловсролын зорилтот хөтөлбөр, шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, бодлогын шинэ арга хэрэгслүүдийг ашиглах шаардлагатай байгаа юм.

Боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, шилжин суурьшсан болон бусад шалтгаанаар сургууль завсардсан хүүхдүүдийг сургуульд хамруулахын тулд сургууль, багш нарын зүгээс нэмэлт хүчин чармайлт гаргах боломж, хөшүүргийг нэвтрүүлэх нь тулгамдсан асуудал хэвээр байна. Сонгинохайрхан дүүрэгт 2010 онд хийсэн судалгаагаар сургууль завсардсан болон огт элсээгүй байсан 33 хүүхдийн нөхцөл байдлыг эргэн тандахад сургуульд тууштай хамрагдсан хүүхэд алга байлаа. Эдгээр хүүхэд сургуульд орсон боловч сурлагын хоцрогдолтой шалтгаанаар гарсан, албан бус боловсролын сургалтуудад хамрагдаж байгаад орхисон, эсвэл сургуульд элсэх оролдлого хийгээгүй байв. Хотын захын

хорооллын сургууль, багш нарын ачаалал их байдаг ч шилжин ирсэн болон түр завсардаад буцаж орж байгаа хүүхдийн сурлагын амжилтыг ахиулах нэмэлт хичээл оруулах, сургуулийн шинэ орчин, хамт олонтойгоо дасан зохицоход нь туслах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах хөшүүргийг бодлогоор бий болгосноор эдгээр бэрхшээлийг даван туулах юм.

Үндэсний цөөнхийн хэл, соёлын эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулсны дагуу Баян-Өлгий аймгийн сургуулиуд казак-монгол, урианхай-монгол, тува-монгол хос хэлний боловсролыг хэрэгжүүлж байна. Харамсалтай нь казак хүүхдүүдийн монгол хэлний сургалтын чанар муу, тува болон урианхай хүүхдүүдийн эх хэлний сургалтын орчин бүрдэхгүй байгаа нь хос хэлний боловсролын зарчим хэрэгжихгүй байгааг харуулж байна. 2010 онд эхлүүлж 2011 онд дуусгасан “Казак хүүхдүүдийн хос хэлний боловсрол” судалгаагаар Монголд өнөөг хүртэл хос хэлний боловсролын үзэл баримтлал, онол арга зүй байхгүй учраас хос хэлний сургалтын стандарт, хөтөлбөр боловсруулах, хоёр хэлний

цагийн нөөцийг хуваарилах, хос хэлний багш бэлтгэх, сурах бичиг зохиох зэрэг ажил хийгдэхгүй байна. Уг асуудлаар Латвийн хос хэлний боловсролын мэргэжилтэн М. Голубева Монголын нөхцөлд байдалд ажиглалт шинжилгээ хийхээр Баян-Өлгий





аймагт ажилласан бөгөөд ажиглалтдаа тулгуурлан багш нар, боловсролын судлаач мэргэжилтнүүд, иргэний нийгмийн төлөөлөгчдөд зориулан сургалт хийлээ. Сургалтаар эх хэлээр нь сургалтыг эхлүүлээд, аажмаар хоёрдахь хэлийг

нэмж эзэмшүүлэх арга зүйн талаар тайлбарлан хоёрдахь хэлийг 3-4 дүгээр ангиас нэмж оруулж ирэхдээ түүх, уран зохиолын хичээлийг дагнан монгол хэлээр заах, эсвэл бүх хичээлийн цагийг эн тэнцүү хувааж хоёр хэлийг дараалуулан

ашиглах зэрэг арга зүйн шийдлүүдийн талаар хэлэлцсэн юм. Уг сургалтад Боловсролын Хүрээлэнгийн шинээр байгуулаад байгаа казак хэлний нэгжийн ажилтнууд мөн оролцож, цаашид хамтран ажиллахаар тохиролцлоо.



Казак гэр

# ЗАЛУУЧУУДЫН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

ННФ 2009 оноос эхлэн хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих загвар хөтөлбөрүүдийг дэмжин ажиллаж байна. 2011 онд “Иргэний Боловсрол Төв” төрийн бус байгууллагатай хамтран хотын захын хорооллын нийгмийн ухааны багш нарын туслалцаатай ахлах ангийн хүүхдүүдийг орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд оролцуулах арга замыг боловсруулах жижиг төслүүдэд дэмжлэг үзүүллээ. “Иргэний Боловсрол Төв” нь сургуулийн сурагчдыг өөрсдийн амьдарч байгаа

орчинд тулгарч буй асуудлуудыг хуулийн хүрээнд шийдвэрлэх арга барилд сургах арга зүйг “Иргэн” төслийн хүрээнд нийслэлийн 53, 9 дүгээр сургуулийн багш, сурагчдад нэвтрүүлж, 10 гаруй баг байгуулан 2011 оны 8 дугаар сараас идэвхтэй ажиллаж эхэлжээ. Төслүүдийн тайлан 2012 оны 3 дугаар сард бэлэн болох ба нэгдсэн байдлаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр үр дүнг нь мэдээлэх юм.

ННФ 2011 онд өмнөх жилүүдэд хэрэгжүүлсэн “Хүүхэд, залуучуудын

хөгжлийг дэмжих төсөл”-ийг үргэлжлүүлэн Залуучуудын оролцооны хөтөлбөр болгон өргөжүүллээ. 2011 оны 7 дугаар сард Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Залуучуудын хөтөлбөрөөс Киргизстан улсад хэрэгжүүлсэн “21 дүгээр зууны залуус: мэтгэлцээн ба медиа продакшн” сэдэвт олон улсын зуны сургалтад Монголын таван оролцогчийг хамрууллаа. Одоо эдгээр оролцогчийн дэмжлэгтэйгээр ижил төстэй сургалтыг Монголд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.



# ХӨГЖЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

Хөгжлийн Мэдээллийн төв 2011 онд мэдээллийн гол үйлчилгээгээ онлайнаар хүргэх e-мэдээллийн төв болж, дижитал мэдээллийг олон хувилбараар (pdf, html, ePub, Kindle ) орчин үеийн шинэ тоног төхөөрөмж (iPad, iPhone, E-Reader) дээр ашиглах боломжийг турших зорилт тавин ажиллалаа.

Энэ зорилтын хүрээнд онлайн санг өргөжүүлж тус төвөөс онлайнаар авч болох бүх үйлчилгээг нэг дор нэгтгэн хэрэглэгчид мэдээлэл хайх, захиалахад хялбар дөхөм болгон шинэчиллээ. Төвөөр үйлчлүүлэгчид хөгжлийн сэдвээрх судалгааны тайлан, үнэлгээ, хэлэлцэгдэж байгаа зарим хуулийн төсөл, түүнтэй холбогдсон хэлэлцүүлгийн тэмдэглэл, зөвлөмж зэргийг e-мэдээллийн сангаас хайж бүрэн эхээр нь татан ашиглаж байна. Үүнээс гадна дэлхийн олон оронд хүртээмжтэй Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн байгууллага (OECD), Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банкны E-номын сан, Кэмбрижийн сэтгүүлийн сан, Оксфордын лавлах болон Жэй-Стор (JSTOR) онлайн сангийн мэдээллүүдийг бүрэн эхээр нь тус төвийн эрхээр хандан

авч байна. Одоогоор төвийн онлайн сан Монголын нийгэм, эдийн засгийн холбогдолтой 1000 орчим судалгааны тайлан, үнэлгээг агуулж байна. Мөн 5,000 гаруй хэвлэмэл ном, сэтгүүлээс онлайн каталогиор хайлт хийн үйлчлүүлэх, захиалах боломжийг бүрдүүлэв. 2011 онд 183750 хүн онлайн мэдээллийн сангаас үйлчилгээ авч, каталогиос 96,000 орчим удаа хайлт хийгджээ.

Энэ хугацаанд танхимын үйлчилгээ нь үндсэндээ анх удаа ирж мэдээлэл авах, эсвэл гаднын онлайн сангуудад нэвтэрч ашиглах зорилгоор ирж буй хүмүүст хүртээмжтэй байсан бол байнгын үйлчлүүлэгчид гишүүнчлэлийн үйлчилгээг илүүтэй сонгох болов. Одоогоор 150 орчим хүн гишүүнчлэлийн үйлчилгээ авч байгаагаас 32 хүн байгууллагын гишүүнчлэлтэй байна. Гэрээр ном зээлэх үйлчилгээний товч статистикийг авч үзвэл давхардсан тоогоор 537 хүн 1800 гаруй ном, сэтгүүлийг гэрээр авч ашиглажээ. Монгол Улсын статистикийн эмхэтгэл, Айн Рендийн “Эх сурвалж”, Джон Перкинсийн “Эдийн засгийн алуурчны наминчлал”, Д.Боазын

“Либертарианизм”, Жеймс Гуартнийн “Эдийн засаг энгийнээр”, “Иргэний эрх зүйн хөтөч” номууд, Time, Economics, Harvard Business Review, Forbes сэтгүүлүүд хамгийн олон удаа буюу дунджаар 15-50 удаа ашиглагджээ.

Мэдээлэл солилцох, хүлээн авах хүрээнд тус төвийн мэдээллийн санд жилд дунджаар 200-250 шинэ ном, судалгаа нэмэгддэг ба тэдгээрийн ихэнх нь Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк болон Конгрессийн номын сангийн ном солилцооны хөтөлбөрийн хүрээнд ирж байна. Мөн шинээр гарч олон улс оронд уншигдаж байгаа ч монголын уншигчдад тэр бүр хүртээмжгүй байдаг гадны хэвлэн нийтлэлчдийн номыг захиалан авч байна.

Хөгжлийн мэдээллийн төв 2012-2013 онд мэдээлэл түгээх үйлчилгээндээ технологийн хөгжил, давуу талыг түшиглэн түгээлтийн шинэ хэрэгсэл, сувгуудыг илүүтэй ашиглах бодлого баримталж онлайн үйлчилгээ, электрон агуулгын чанарыг сайжруулж, төрлийг олшруулахыг зорьж байна.

# «www.forum.mn» ПОРТАЛ САЙТ

“Нээлттэй Нийгэм Форум” портал сайт нь Монгол дахь бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх үйл

явц, бодлогын шийдвэрийн талаарх мэдээллээр олон нийтийг хангах, бодлогод хяналт тавих, үнэлэх зэрэг

чиглэлээр 2011 онд доорх ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

## НИЙТЛЭЛ & NEWS HEADLINES

Монголын хөгжлийн асуудлаарх нийтлэл, өгүүллийг олны хүртээл болгодог “Онцлох мэдээ” буланд нийтдээ 500 гаруй мэдээ мэдээлэл, нийтлэл, ярилцлага агуулагдаж байна. Зонхилох сэдвүүд нь засаглалын асуудлууд, татвар, уул уурхай, байгаль орчин, хүн амын амьжиргаа, хүнс,

хөдөө аж ахуй, гадаад, дотоод бодлого, даяаршлын тухай бөгөөд эрдэмтэн судлаачид, багш нар, сэтгүүлчид, төрийн албан хаагчид өөрсдийн бичсэн нийтлэл, өгүүллээ Монголын улс төр, эдийн засгийн онцлох үйл явдлын талаарх тойм мэдээллийг тогтмол хүргэж байна.

## ТОГТМОЛ ЯВУУЛДАГ АЖИГЛАЛТУУД:

Улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн талаарх шүүмж анализ, сонгуулийн үйл явцын мониторинг зэрэг өргөн хүрээтэй мэдээ материалыг нэг дор байрлуулан, олон нийтэд түргэн шуурхай танилцах боломжийг бүрдүүлж, мэдээллийг багцаар нь хүргэж байна. Тус портал

нь 2004 оноос эхлэн жил бүрийн улсын төсвийг УИХ-аар хэлэлцэн батлах үйл явц, төсвийн хүрээний тодотголтой холбоотой багц мэдээллүүдийг тогтмол толилуулдаг болсон. Тухайн жилийн улсын төсвийн дэлгэрэнгүй төслийг бүрэн эхээр нь вэб сайтад байрлуулж, олон нийтийн саналыг нь хүлээн авч байна.

## БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

“Бодлогын хэлэлцүүлэг” буланд хууль тогтоох үйл явц дахь иргэдийн оролцоог боловсронгуй болгоход чиглэсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай

хуулийн төсөл, Сонгуулийн үйл явцын эрх зүйн зохицуулалт зэрэг асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор тэдгээртэй холбоотой баримт бичиг, судалгаа, санал зөвлөмжийг багцлан толилууллаа.

## ЭХ СУРВАЛЖ

Тайлант хугацаанд Монголын нийгэм, эдийн засгийн хөгжлийн сэдвээр донор байгууллагууд болон бусад судалгааны төвийн хийсэн шинэ судалгаануудыг бүрэн

эхээр нь pdf форматаар байрлуулав. Мөн бодлогын асуудлаар хэвлэгдэж буй ном товхимол, гарын авлагуудыг танилцууллаа.

# «БОДЛОГЫН АСУУДАЛ» ЦУВРАЛ

ННФ-ын 2010 онд шинээр эхлүүлсэн “Бодлогын асуудал” цуврал нь тухайн цаг үед анхаарал татаж буй асуудлаарх үнэлгээ, дүгнэлт, тоо баримтад анализ хийж боловсруулсан нэлээд гүнзгий мэдээлэл өгөх эх сурвалж болов.

2011 онд “Шүүхэд хэрэг маргааныг хянан хэлэлцэх ажиллагаан дахь иргэдийн оролцоо”, “Сонгуульд автоматаар санал тоолоход зайлшгүй анхаарах асуудлууд”, “Монгол Улсын төсвийн хуулийн төслийн талаарх санал” зэрэг сэдвээр тойм бэлтгэн бодлого боловсруулагчид болон олон нийтийн анхаарлыг хандууллаа.

# БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Бодлогын холбогдолтой шийдвэр гаргалтыг бие даасан, хараат бус судалгаа, шинжилгээгээр дэмжих зорилготой Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрт 2011 онд хоёр судалгааны багийг

хамруулан, арга зүйн болон санхүүгийн дэмжлэгээр ханган ажиллалаа. Энэхүү хөтөлбөрийн үндсэн зорилт нь нийгмийн шинжлэх ухааны хавсарга салбар болох бодлогын судалгааны арга зүйг Монголын судлаачдад

эзэмшүүлэн, тэдний боловсруулсан бодлогын хувилбарт шийдлүүдийг олон нийт, бодлого боловсруулагчдад хүргэн, бодлогын яриа хэлэлцүүлгийг баяжуулахад оршиж байна.

## 2011 ОНЫ БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТӨСЛҮҮД

| Судалгааны ажлын чиглэл  | Судалгааны багийн бүрэлдэхүүн   |
|--|---|
| Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төрийн бодлого              | Н.Соёлгэрэл, эрдэм шинжилгээний ажилтан, Стратеги Судлалын хүрээлэн<br>Ц.Бумхорол, судлаач, Стратеги Судлалын Хүрээлэн  |
| Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нийгмийн цогц үйлчилгээг хүргэх тогтолцоо | Ч. Ганбилэг, Дэд Захирал, 55 дугаар дунд сургууль<br>Л.Зулцэцэг, судлаач, “Адра-Монгол” байгууллага<br>Ю.Отгонбилэг, Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн Яам<br>Б.Баясгалантай, Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний төв |

# ЭРДМИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Нээлттэй Нийгэм  
Хүрээлэнгийн Будапешт хотод төвтэй Дээд боловсролыг дэмжих хөтөлбөр нь нийгмийн ухааны дээд боловсрол олгох сургалтын агуулга, арга зүйн шинэчлэлд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд 2004 оноос Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. 2011 онд хөтөлбөрийн дотоод үнэлгээг хийж, сүүлийн долоон жилд Зүүн болон Төв Европ, хуучин ЗХУ-ын улс орнууд, мөн Төв Ази болон Монголын төрийн их дээд сургуулийн эрдэмтэн багш нарт үзүүлсэн дэмжлэг

нь эдгээр бүс нутгийн нийгмийн ухааны сургалт, судалгааны агуулга, арга зүйг шинэчлэх ажилд ямар нөлөө үзүүлснийг нэгтгэн дүгнэх өргөн хүрээтэй ажлыг хийлээ. Үнэлгээний ажилд Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөрт одоо хамрагдаж буй 400 гаруй багш, урьд нь хамрагдаж байсан 200-300 хүн оролцон, өөрсдийн туршлага, үнэлгээг ирүүлж байгаа нь үнэлгээний мэдээллийн бааз болж байна. Үнэлгээний ажлын үр дүн 2012 оны эхний хагаст гарах юм.

2011-2012 оны хичээлийн жилд Монголоос хоёр сургуулийн гурван тэнхмийн 20 орчим багш энэ хөтөлбөрт хамрагдаж байна. Үүнд МУИС-ийн Нийгмийн Ухааны Сургуулийн Нийгэм, соёлын антропологийн тэнхим, Эдийн Засгийн Сургуулийн Эдийн засгийн онолын тэнхим, ЭМШУИС-ийн Нийгмийн Эрүүл Мэндийн Сургуулийн Эпидемиологи, биостатистикийн тэнхмийн эрдэмтэн багш нар багтаж байна.

## 2011-2012 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ЭРДМИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАЖ БАЙГАА ТЭНХИМ, БАГШ НАРЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

| Тэтгэлэг хүртэгч   | Төгссөн сургууль, зэрэг  | Судалгааны сонирхол  |
|--|--|--|
| <b>МУИС-ИЙН НИЙГЭМ, СОЁЛЫН АНТРОПОЛОГИЙН ТЭНХИМ</b>                                    |  |  |
| Д. Бум-Очир  | PhD, Нийгмийн антропологи, Кембриджийн Их Сургууль, 2006                 | Хөгжлийн антропологи, бөө шашин судлал   |
| П. Чулуунбат   | MPhil, Нийгмийн антропологи, Кембриджийн Их Сургууль, 2007               | Улс төрийн антропологи, Өвөр Азийн бүс нутаг судлал  |
| Б. Цэцэнцолмон   | Магистр, угсаатны хөгжим судлал, Тайванийн Үндэсний Урлагийн Их Сургууль | Үндэсний хөгжим судлал, урлагийн антропологи, ардын урлаг  |
| Ж. Лхагвадэмчиг  | Магистр, Буддын шашин судлал, ХонгКонгийн Их Сургууль                    | Шашны антропологи, Монгол болон Өвөр Ази судлал, хөгжлийн антропологи, хэлний антропологи  |
| Зөвлөх: Дэвид Снийт, Кембриджийн Их Сургуулийн Нийгмийн антропологийн тэнхмийн эрхлэгч | PhD, Нийгмийн антропологи, Кембриджийн Их Сургууль, 2006                 | Өвөр Азийн улс төрийн байгууламжийн түүх, нүүдлийн мал аж ахуй, газар ашиглалт болон байгаль орчин, пост-социалист нийгмийн өөрчлөлтүүд, улс төрийн соёл болон эдийн засгийн институцууд, хөгжлийн антропологи |

| Тэтгэлэг хүртэгч  | Төгссөн сургууль, зэрэг  | Судалгааны сонирхол   |
|---|--|---|
| <b>ЭМШУИС-ИЙН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУРГУУЛЬ</b>   |  |   |
| Г. Даваа  | PhD, ЭМШУИС, 2009. Магистр, Нийгмийн эрүүл мэнд, Хибру Их Сургууль, Израиль, 2004. | Халдварт болон халдварт бус өвчин судлал, эмнэлгийн орчин дахь халдварлалт  |
| Д. Даваалхам  | PhD, нийгмийн эрүүл мэнд, Жичи Эрүүл Мэндийн Их Сургууль, Япон 2007                | Вируст гепатит судлал, Кавасакигийн өвчин, хавдар судлал, зүрх судасны өвчин  |
| Д. Гантуяа  | MPH, нийгмийн эрүүл мэнд, Депретсений Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль, Унгар       | Халдварт бус өвчний эпидемиологи, Эх хүүхдийн эрүүл мэнд, Эрүүл мэндийн тусламж   |
| Зөвлөх: Луис Анн<br>Макнат, Олбани дахь Нью Йорк Мужийн Их Сургуулийн Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль                           | PhD  | Эпидемиологи,   |
| <b>МУИС-ИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНХИМ</b>  |  |   |
| Ч. Нарантуяа  | Магистр, экономикс, Сиднейн Их Сургууль, Австрали                                  | Төсөв, санхүү, мөнгөний бодлого, институцууд  |
| Б. Алтанцэцэг   | PhD, экономикс, Виржиния Мужийн Их Сургууль, АНУ                                   | Макро эдийн засгийн онол, олон улсын эдийн засаг  |
| Б. Отгонтөгс  | PhD, Боловсролын эдийн засаг, Колумбийн Их Сургуулийн Багшийн Коллеж, АНУ          | Боловсролын эдийн засаг, хөдөлмөрийн эдийн засаг  |
| Б. Эрдэнэбат  | PhD, экономикс, Манчестерийн Их Сургууль   | Хэрэглээнийн эконометрикс, санхүүгийн экономикс, олон улсын бизнесийн мөчлөг, инфляц, нөөц баялгийн хяслан  |
| Б. Соёлмаа  | PhD, экономикс, Манчестерийн Их Сургууль   | Макро эдийн засгийн загварчлал, эдийн засгийн өсөлт, засаглал, микро санхүү, орлого хуваарилалт ба ядуурал  |
| Зөвлөх:<br>Жон Андерсон<br>Дэд захирал, экономиксийн профессор, Бизнесийн Удирдлагын Сургууль, Небраска Мужийн Их Сургууль, АНУ | PhD, экономикс, Клермонт Их Сургууль   | Холбооны татварын бодлого, мужийн болон орон нутгийн татварын бодлого, үл хөдлөх хөрөнгийн татвар, хотын газар зохион байгуулалт, орон сууцжуулалтын эдийн засаг, шилжилтийн эдийн засаг дахь төсөв, мөнгөний бодлого |



# ХЭВЛЭН НИЙТЛЭЛ

Нээлттэй Нийгэм Форумаас хөгжлийн бодлого боловсруулах, энэ чиглэлээр өрнөж буй хэлэлцүүлэгт иргэний нийгмийн байгууллагууд, иргэд үр

дүнтэй оролцоход хувь нэмэр болох зорилгоор судалгааны тайлан, мониторингийн үр дүн, ном зүй, иргэдийн гарын авлага зэргийг хэвлэн гаргадаг билээ. Энэхүү

хэвлэн нийтлэлийн бодлогын хүрээнд 2003 оноос хойш нийтдээ 150-иад нэрийн 62,400 ном, судалгаа, гарын авлага хэвлэн гаргажээ.

## 2011 ОНД

- Орон нутгийн төсвийн зарлагын шинжилгээ
- Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2011
- Эрчим хүчний асуудалд холбогдох ном зүй
- Уурхайн хаалт: Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь
- Төрийн нууцын тухай өнөөгийн хандлагыг өөрчлөх замаар иргэдийн мэдэх эрхийг хангах нь
- Ерөнхий боловсролын сургуулийн Иргэний боловсролын сургалтад хийсэн үнэлгээ, мониторинг
- Шүүх хуралдааны ажиглалтын тайлан зэрэг ном, судалгааг хэвлэн гаргаад байна.

ННФ-аас хэвлэн гаргаж буй эдгээр ном, судалгаа нь бодлого боловсруулагчид, яам тамгын газрын холбогдох ажилтнууд, салбарын судлаачид, төрийн бус байгууллага, хот хөдөөгийн

нийтийн номын сан болон Форумаас зохион байгуулдаг сургалт, хэлэлцүүлэгт оролцогчдод үнэ төлбөргүй тараагдаж байна. Тайлангийн хугацаанд нийтдээ 21,000 гаруй хэвлэмэл бүтээгдэхүүн

тараагджээ. Мөн зарим судалгааны тайланг ePub, eBook, Kindle формат руу хувирган нийтэд түгээх туршилт хийгдсэн нь хэрэглэгчдийн шаардлагад нийцсэн үйлчилгээ болов.

# ОРЧУУЛГЫН ТӨСӨЛ

Нээлтэй Нийгэм Форум 2004 оноос орчуулгын төсөл эхлүүлж жил бүр 1-2 ном сонгон хэвлэн нийтэлж, нийтийн хүртээл болгож байна. Энэ төслийн хүрээнд нийтдээ 20 орчим ном орчуулж гаргаснаас МонСудар хэвлэлийн газартай хамтран эхний 10 номыг хэвлэсэн билээ. 2011 онд “Сонгуулийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалт”, “Иргэддээ үйлчилж, төрт ёсны үнэт

зүйлсээ хадгалах: Өрсөлдөөнт ертөнцөд төрийн захиргааг сайжруулах нь” зэрэг номыг орчуулан хэвлээд байна. Орчуулгын төслийн хүрээнд гарч буй номуудаа 50-70 хувийн хөнгөлөлттэй үнээр борлуулж орлогыг Орчуулгын санд төвлөрүүлэн дараа дараагийн ном хэвлэхэд зарцуулж байна.

Нэрд гарсан эдийн засагч, судлаач-туурвигчдын баримт нотолгоо, онолын

судалгаанд үндэслэн бичигдсэн энэхүү орчуулгын номууд нь нийгэмд өрнөж буй хөгжлийн асуудлуудыг таньж мэдэх, өөр өнцгөөс харах, тэдгээрийн учир шалтгааныг ойлгож онолын үндэслэлийг судлах, бусад орны туулж өнгөрүүлсэн туршлага зэрэгтэй танилцахад хувь нэмэр болохуйц чухал ач холбогдолтой бүтээлүүд байдаг юм.



Манай орны хамгийн том мөсөн гол нь Таван Богд ууланд байдаг, 20 км урт, 5 км өргөн Потанины мөсөн гол юм

БУСАД

# «ДОРНО ДОРНО - ХИЛ ХЯЗГААРГҮЙ ТҮНШЛЭЛ» БҮСИЙН ХӨТӨЛБӨР

“Дорно Дорно: Хил Хязгааргүй Түншлэл” хөтөлбөр нь олон улсын хэмжээнд нээлттэй нийгмийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмэр болох ерөнхий зорилгын хүрээнд иргэний нийгмийн төлөөлөгчид, төрийн бус байгууллагууд өөр хоорондоо үзэл бодол, мэдээлэл, туршлага солилцох санаачилга, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг. Уг хөтөлбөр 1991 оноос эхлэн хэрэгжихдээ хуучин социалист орнууд, Төв болон Зүүн Европын орнуудыг хамардаг байсан бол эдүгээ Ази, Африк, Латин Америкийн орнуудын иргэний нийгмийн байгууллагуудад дэмжлэг үзүүлж өргөжин тэлжээ. Хөтөлбөр нь нээлттэй нийгмийн үзэл санаанд чухал байр суурь эзэлдэг үндсэн сэдвүүд болох сайн засаглал, нийгмийн хариуцлага, нийгмийн бодлого, хүний эрх, шударга ёс, олон улсын болон геополитикийн харилцаа зэрэг чиглэл, сэдэвт түлхүү ач холбогдол өгдөг. Жил бүр Монголын иргэний нийгмийн төлөөлөл, нийгмийн салбарын экспертүүд Дорно Дорно хөтөлбөрийн хүрээнд зохиогдож буй олон улсын болон бүсийн хэмжээний хурал, семинар, сургалтуудад

оролцсоор ирснээс гадна манай орны туршлагыг судлах, суралцах хүсэлтэй бусад улсын иргэний нийгэм, нийгмийн идэвхтнүүд, төлөөлөгчдөд мөн дэмжлэг үзүүлж байна.

2011 оны дөрөвдүгээр сарын 11-нээс 15-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Киргиз Улсын Парламентын дэд дарга Бакыт Торобаев тэргүүтэй төлөөлөгчид УИХ-ын үйл ажиллагаатай танилцах зорилгоор манай улсад айлчилсан юм. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Парламентын дэд даргаас гадна Бүгд Найрамдах Киргиз Улсын Ерөнхийлөгчийн Парламент дахь төлөөлөгч, Парламентын хүний эрх, хуульт ёс, төрийн байгуулалт, орон нутгийн удирдлага, авилгатай тэмцэх асуудал хариуцсан хороодын дарга, гишүүдээс гадна хүүхдийн эрхийг хамгаалах, эрх зүйн шинэчлэлийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл багтсан болно. Төлөөлөгчид УИХ-ын үйл ажиллагаанд ил тод байдал, иргэний нийгмийн оролцоог хэрхэн хангадаг, тухайлбал, төсөв, сонгуулийн хууль зэрэг чухал асуудлаар шийдвэр гаргахад иргэдийг хэрхэн оролцуулдаг, Монгол Улсад шүүх эрх мэдлийн шинэчлэл,

хүний эрхийг хамгаалах асуудал ямар түвшинд байгаа талаар манай төр, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчидтэй уулзаж туршлага судаллаа.

2011 оны тавдугаар сарын 9-15-нд Монголын Хэвлэлийн Хүрээлэнгийн таван мэргэжилтэн Дорно Дорно хөтөлбөрийн дэмжлэгээр Словенийн Любляня хотноо сэтгүүл зүйн болон хэвлэл мэдээллийн бодлогын судалгаа явуулдаг Энхтайвны Хүрээлэнд зочилж, хэвлэл




мэдээллийн шүүмж, анализыг хийх талаар туршлага судаллаа. Монголд эдүгээ маш олон тооны хэвлэл мэдээллийн хэрэгсэл байгаа ч хэвлэл мэдээллийн чөлөөт, бие даасан байдал туйлын хангалтгүй байна. Хэвлэл мэдээллийн шүүмж нь сонирхлын зөрчил, хэвлэл мэдээлэл дэх сэтгүүл зүйн стандартын тулгамдсан асуудлуудыг задлан шинжилж олон нийтэд хүргэхэд чухал ач холбогдолтой юм. Монголд хэвлэл мэдээллийн шүүмжийн шинэ стандартыг

тогтоох, хэвлэл мэдээллээр дамжуулж нийгэмд ардчилал, олон ургальч үзлийг бэхжүүлэхэд энэ аялал чухал алхам болсон гэж хөтөлбөрийн зүгээс үзэж байна.

2011 оны 10 дугаар сарын 6-8-нд Дорно Дорно хөтөлбөрийн дэмжлэгээр Армени улсын Ереван хотноо зохион байгуулагдсан “Ардчилал, иргэний нийгмийн ирээдүйн төлөв” сэдэвт олон улсын бага хуралд Монголын иргэний

нийгмийг төлөөлөн Филантропи Хөгжлийн төвийн хуульч Ч. Мөнхцэцэг оролцлоо. Энэ хуралд Армени улсын болон Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Америкийн Нэгдсэн Улс, Төв болон Зүүн Европын орнууд болон Тусгаар Улсуудын Хамтын Нөхөрлөл зэрэг дэлхийн 30 гаруй орны 100 гаруй төлөөлөгчид оролцон хүний эрх, төрийн ил тод байдал, ардчиллын институциуд, сайн засаглалын асуудлаар санал солилцсон юм.



Дорнод Монголын талд жаргаж буй наран. Гэрэл зургийг Э.Мөнхжаргал

# САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нээлттэй Нийгэм Форум 2012 онд нийт 1,300,000 ам.долларын төсөвтэй ажилласан ба үүнээс \$ 1,120,500 Нээлттэй Нийгэм Хүрээлэн болон Соросын сангийн сүлжээний хөтөлбөрүүд, \$ 62,700-АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг, \$ 94,700 Дэлхийн Банк, \$ 10,000 Emory Их Сургуулиас тус тус санхүүжигдсэн болно.

## НИЙТ ЗАРЦУУЛАЛТ

\$ доллар

| Хөтөлбөр   | Тэтгэлгийн зардал | Үйл ажиллагааны зардал | Нийт зардал      |
|--|-------------------|------------------------|------------------|
| <b>ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР</b>                                   |                   |                        |                  |
| Хүний эрх  | 4,720             | 9,626                  | 14,346           |
| Шүүхийн хараат бус байдал                                    | 68,666            | 29,489                 | 98,155           |
| Төрийн ил тод хариуцлагатай байдал, Иргэний нийгмийн оролцоо | 86,584            | 78,225                 | 164,809          |
| Чөлөөт, шударга сонгууль                                     |                   | 1,357                  | 1,357            |
| Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө                                 | 8,064             | 1,114                  | 9,178            |
| <b>ЭДИЙН ЗАСГИЙН ХӨТӨЛБӨР</b>                                |                   |                        |                  |
| Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилга                | 12,827            | 24,243                 | 37,070           |
| Олборлох салбарын бодлогын асуудлууд                         |                   | 24,021                 | 24,021           |
| Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо                    | 32,881            | 15,980                 | 48,861           |
| Эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ                         | 1,203             | 159,682                | 160,885          |
| Бизнесийн орчин  |                   | 9,035                  | 9,035            |
| Орон нутгийн эдийн засгийн хөгжил                            | 13,071            | 1,213                  | 14,284           |
| <b>НИЙГЭМ, БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР</b>                          |                   |                        |                  |
| Нийгмийн үйлчилгээний хүрээмж                                | 9,567             | 18,492                 | 28,059           |
| Боловсролын үйлчилгээний хүртээмж                            | 16,039            | 1,287                  | 17,326           |
| Залуучуудын оролцоог дэмжих хөтөлбөр                         |                   |                        | -                |
| <b>ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ</b>      |                   |                        |                  |
| Хөгжлийн мэдээллийн төв                                      | -                 | 43,730                 | 43,730           |
| Портал сайт  | -                 | 30,255                 | 30,255           |
| Бодлогын асуудал / Цуврал /                                  | -                 | 12,568                 | 12,568           |
| Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр                       | 8,975             | 16,561                 | 25,536           |
| Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөр                                   |                   | 20,194                 | 20,194           |
| Дорно Дорно хөтөлбөр   | 17,130            | 4,829                  | 21,959           |
| <b>ЗАХИРГАА</b>  | -                 | 365,832                | 365,832          |
| <b>НИЙТ ДҮН</b>  | <b>279,727</b>    | <b>867,732</b>         | <b>1,147,460</b> |

## ТЭТГЭЛГИЙН НИЙТ ЗАРЦУУЛАЛТ

\$ доллар

| Хөтөлбөр  | Байгууллагад олгосон | Хувь хүнд олгосон | Тэтгэлгийн зардал |
|---|----------------------|-------------------|-------------------|
| <i>ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР</i>                                      |                      |                   |                   |
| Хүний эрх   | 4,720                |                   | 4,720             |
| Шүүхийн хараат бус байдал                                       | 53,646               | 15,020            | 68,666            |
| Төрийн ил тод хариуцлагатай байдал,<br>Иргэний нийгмийн оролцоо | 86,584               |                   | 86,584            |
| Чөлөөт, шударга сонгууль  |                      |                   |                   |
| Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө                                    | 8,064                |                   | 8,064             |
| <i>ЭДИЙН ЗАСГИЙН ХӨТӨЛБӨР</i>                                   |                      |                   |                   |
| Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилга                   |                      | 12,827            | 12,827            |
| Олборлох салбарын бодлогын асуудлууд                            |                      |                   |                   |
| Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо                       | 32,881               |                   | 32,881            |
| Эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ                            | 1,203                |                   | 1,203             |
| Бизнесийн орчин   |                      |                   |                   |
| Орон нутгийн эдийн засгийн хөгжил                               | 13,071               |                   | 13,071            |
| <i>НИЙГЭМ, БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР</i>                             |                      |                   |                   |
| Нийгмийн үйлчилгээний хүрээмж                                   | 9,567                |                   | 9,567             |
| Боловсролын үйлчилгээний хүртээмж                               | 3,711                | 12,328            | 16,039            |
| Залуучуудын оролцоог дэмжих хөтөлбөр                            |                      |                   |                   |
| <i>ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ</i>         |                      |                   |                   |
| Хөгжлийн мэдээллийн төв   |                      |                   | -                 |
| Портал сайт   |                      |                   | -                 |
| Бодлогын асуудал / Цуврал /                                     |                      |                   | -                 |
| Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр                          |                      | 8,975             | 8,975             |
| Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөр                                      |                      |                   |                   |
| Дорно Дорно хөтөлбөр  | 15,420               | 1,710             | 17,130            |
| <i>ЗАХИРГАА</i>   |                      |                   |                   |
|   |                      |                   | -                 |
| <b>НИЙТ ДҮН</b>   | <b>228,867</b>       | <b>50,860</b>     | <b>279,727</b>    |

## 2011 ОНД ОЛГОСОН НИЙТ ТЭТГЭЛГИЙН ЖАГСААЛТ

\$ доллар

|    | Байршил          | Тэтгэлэг хүртэгчийн нэрс   | Төрөл | Тэтгэлгийн дүн |
|----|------------------|--|-------|----------------|
| 1  | Улаанбаатар хот  | Ч.Ганбилэг-баг   | Баг   | 12,328         |
| 2  | Улаанбаатар хот  | Д.Сүхгэрэл   | Иргэн | 1,684          |
| 3  | Улаанбаатар хот  | Б.Оюундарь   | Иргэн | 1,684          |
| 4  | Улаанбаатар хот  | Д.Ганбаатар  | Иргэн | 1,684          |
| 5  | Улаанбаатар хот  | Б.Болдбаатар   | Иргэн | 2,145          |
| 6  | Улаанбаатар хот  | Д.Сүхгэрэл   | Иргэн | 2,360          |
| 7  | Улаанбаатар хот  | Ц.Отгонбаатар  | Иргэн | 2,360          |
| 8  | Улаанбаатар хот  | Д.Цэрэнжав   | Иргэн | 1,690          |
| 9  | Улаанбаатар хот  | Д.Цэрэнжав   | Иргэн | 1,970          |
| 10 | Улаанбаатар хот  | Н.Баярсайхан   | Иргэн | 1,970          |
| 11 | Улаанбаатар хот  | Ж.Баярцэцэг  | Иргэн | 2,205          |
| 12 | Улаанбаатар хот  | Д.Заяабат  | Иргэн | 1,970          |
| 13 | Улаанбаатар хот  | Н.Ганбаяр  | Иргэн | 1,940          |
| 14 | Улаанбаатар хот  | П.Цагаан   | Иргэн | 1,940          |
| 15 | Улаанбаатар хот  | Ц.Цогт   | Иргэн | 1,940          |
| 16 | Улаанбаатар хот  | Д.Одбаяр   | Иргэн | 1,940          |
| 17 | Улаанбаатар хот  | З.Эрдэнэ   | Иргэн | 1,410          |
| 18 | Улаанбаатар хот  | Х.Тэмүүжин   | Иргэн | 1,675          |
| 19 | Улаанбаатар хот  | Ч.Мөнхцэцэг  | Иргэн | 1,710          |
| 20 | Улаанбаатар хот  | Ц.Бумхорол   | Иргэн | 3,256          |
| 21 | Улаанбаатар хот  | С.Энхбат   | Иргэн | 2,859          |
| 22 | Улаанбаатар хот  | Н.Соёлгэрэл  | Иргэн | 2,859          |
| 23 | Архангай аймаг   | Хөдөөгийн хөгжлийн ундарга                                       | ТББ   | 2,050          |
| 24 | Баян Өлгий аймаг | Урианхай, Дөрвөд, Тува иргэдийн нийгмийн хөгжлийг дэмжих холбоо  | ТББ   | 2,594          |
| 25 | Баянхонгор аймаг | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чөлөөт үйлдвэрчний эвлэлийн салбар | ТББ   | 2,231          |



|    | Байршил          | Тэтгэлэг хүртэгчийн нэрс   | Төрөл | Тэтгэлгийн дүн |
|----|------------------|--|-------|----------------|
| 26 | Булган аймаг     | Бидний харгуй Булганы ирээдүй                                    | ТББ   | 4,951          |
| 27 | Булган аймаг     | ЛЕОС салбар  | ТББ   | 8,170          |
| 28 | Говьсүмбэр аймаг | Өмгөөлөгчдийн салбар зөвлөл                                      | ТББ   | 1,041          |
| 29 | Дархан Уул аймаг | Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөний салбар                   | ТББ   | 8,787          |
| 30 | Дорноговь аймаг  | Дорнын говийн эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг      | ТББ   | 4,931          |
| 31 | Дорнод аймаг     | Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөний салбар                   | ТББ   | 9,212          |
| 32 | Дундговь аймаг   | Дундговь ардчилал клуб   | ТББ   | 8,738          |
| 33 | Өвөрхангай аймаг | Орон нутгийн санаачилга  | ТББ   | 2,820          |
| 34 | Өвөрхангай аймаг | ЛЕОС салбар  | ТББ   | 5,631          |
| 35 | Өвөрхангай аймаг | Орон нутгийн санаачилга  | ТББ   | 4,644          |
| 36 | Өмнөговь аймаг   | Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөний салбар                   | ТББ   | 7,908          |
| 37 | Сүхбаатар аймаг  | Ажил олгогч эздийн холбооны салбар                               | ТББ   | 2,820          |
| 38 | Төв аймаг        | Ажил олгогч эздийн бизнес холбоо                                 | ТББ   | 8,971          |
| 39 | Увс аймаг        | Сайн тус төв   | ТББ   | 2,499          |
| 40 | Увс аймаг        | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чөлөөт үйлдвэрчний эвлэлийн салбар | ТББ   | 1,515          |
| 41 | Хөвсгөл аймаг    | Хөвсгөл далай ээж  | ТББ   | 2,820          |
| 42 | Хөвсгөл аймаг    | Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн                                    | ТББ   | 6,093          |
| 43 | Хөвсгөл аймаг    | Хөвсгөл эрдэм  | ТББ   | 3,304          |
| 44 | Улаанбаатар хот  | Хэвлэлийн хүрээлэн   | ТББ   | 15,420         |
| 45 | Улаанбаатар хот  | Хэвлэлийн хүрээлэн   | ТББ   | 8,064          |
| 46 | Улаанбаатар хот  | Санхүүгийн зах зээлийн холбоо                                    | ТББ   | 13,071         |
| 47 | Улаанбаатар хот  | Хил хязгааргүй алхам   | ТББ   | 1,547          |
| 48 | Улаанбаатар хот  | Amnesty International  | ТББ   | 4,947          |

|                 | Байршил         | Тэтгэлэг хүртэгчийн нэрс   | Төрөл  | Тэтгэлгийн дүн |
|-----------------|-----------------|--|--------|----------------|
| 49              | Улаанбаатар хот | Хэвлэлийн хүрээлэн   | ТББ    | 1,203          |
| 50              | Улаанбаатар хот | Толгойт хорооллын нутгийн хөгжлийн төв                                 | ТББ    | 2,477          |
| 51              | Улаанбаатар хот | Ногоон цөм   | ТББ    | 8,264          |
| 52              | Улаанбаатар хот | Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын Үндэсний холбоо | ТББ    | 7,689          |
| 53              | Улаанбаатар хот | Бизнесийн эрх зүй судлалын сан   | ТББ    | 3,721          |
| 54              | Улаанбаатар хот | Монголын байгаль хамгаалах иргэний хөдөлгөөнүүдийн эвсэл               | ТББ    | 3,993          |
| 55              | Улаанбаатар хот | Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийн үндэсний төв                | ТББ    | 1,712          |
| 56              | Улаанбаатар хот | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес инкубатор төв                     | ТББ    | 1,610          |
| 57              | Улаанбаатар хот | Хуульч эмэгтэйчүүдийн холбоо   | ТББ    | 2,823          |
| 58              | Улаанбаатар хот | Монголын байгаль хамгаалах иргэний хөдөлгөөнүүдийн эвсэл               | ТББ    | 2,877          |
| 59              | Улаанбаатар хот | Ерөнхийлөгчийн Тамгын Газар  | Төрийн | 43,000         |
| <b>НИЙТ ДҮН</b> |                 |  |        | <b>279,727</b> |

# АЖИЛТНУУД

## Нээлттэй Нийгэм Форумын Удирдах Зөвлөлийн гишүүд

|              |  |
|--------------|--|
| Г. Уранцоож  | Удирдах зөвлөлийн дарга , Хүний Эрх-Хөгжил төвийн тэргүүн                                |
| О. Энхтуяа   | Удирдах зөвлөлийн гишүүн, Nature Conservancy олон улсын байгууллагын Монгол дахь захирал |
| Г. Эрдэнэбат | Удирдах зөвлөлийн гишүүн, МУИС-ийн Хуулийн Сургуулийн багш                               |
| Ч. Хашчулуун | Удирдах зөвлөлийн гишүүн, Үндэсний Хөгжил -Шинэтгэлийн хорооны дарга                     |
| С. Цэрэндорж | Удирдах зөвлөлийн гишүүн, Хүний Эрх -Ардчилал судалгааны төвийн тэргүүн                  |
| Т. Ундарьяа  | Удирдах зөвлөлийн гишүүн, MONFEMNET үндэсний сүлжээний зохицуулагч                       |
| Ж. Үнэнбат   | Удирдах зөвлөлийн гишүүн, Компанийн Засаглалын Хөгжлийн Төв ТББ-ын гүйцэтгэх захирал     |

## Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал:

|                |                 |
|----------------|-----------------|
| П.Эрдэнэжаргал | jargal@forum.mn |
|----------------|-----------------|

## Нээлттэй Нийгэм Форумын ажилтнууд:

|               |  |                     |
|---------------|--|---------------------|
| П.Бадамрагчаа | Засаглалын хөтөлбөр хариуцсан менежер          | badmaa@forum.mn     |
| Н.Дорждарь    | Эдийн засгийн хөтөлбөр хариуцсан менежер       | dorjdari@forum.mn   |
| Б.Мөнхсоёл    | Эдийн засгийн хөтөлбөр хариуцсан менежер       | soyoloo@forum.mn    |
| А.Гэрэлмаа    | Нийгэм, Боловсролын хөтөлбөр хариуцсан менежер | gerelmaa@forum.mn   |
| Д.Энхцэцэг    | Засаглалын хөтөлбөр хариуцсан менежер          | enkhee@forum.mn     |
| О.Сэлэнгэ     | Хөтөлбөрийн туслах ажилтан                     | passistant@forum.mn |
| Б.Үүрийнтуяа  | Хөтөлбөрийн туслах ажилтан                     | fassistant@forum.mn |
| Д.Балжид      | Мэдээллийн төвийн менежер                      | baljid@forum.mn     |
| Д.Баярмаа     | Мэдээллийн ажилтан                             | dircassist@forum.mn |
| Д.Гантуяа     | Порталын ерөнхий редактор                      | gantuya@forum.mn    |
| Д.Жавхлан     | Санхүү, захиргааны захирал                     | javkhlan@forum.mn   |
| Д.Аюуш        | Нягтлан бодогч, тэтгэлгийн менежер             | ayush@forum.mn      |
| Д.Өлзийбадрах | Мэдээлэл сүлжээний зохицуулагч                 | ulzii@forum.mn      |
| Т.Отгонбаяр   | Захирлын туслах                                | otgoo@forum.mn      |
| Б.Баатар      | Жолооч   | baatar@forum.mn     |
| Г.Цэдэвхүү    | Жолооч   | tsedev@forum.mn     |
| Ц.Саруул      | Жолооч   | saruul@forum.mn     |
| Ш.Ганчимэг    | Захиргааны туслах ажилтан                      | ganaa@forum.mn      |

Нийтлэг И-мэйль: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

